Ажил үйлийг хийгч нь олон ч аливааг хийснээ гүйцээгч нь цөөн

Монгол ардын сургаал үг

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.04.25, ПҮРЭВ ~ №077 (1129) ~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~ ҮНЭ: 1000₮

Приус машины батарей сэргээх Монгол дахь анхны үйлдвэр
Нөхөн сэргээсэн батарейндаа зургаан сарын баталгаа өгдөг. > 5

Монголын хүнсний зах зээлд ноёлсон франчайзууд
Шинэ бизнесийг амжилтад хүргэхийн төлөө туулах даваа, бэрхшээл хязгааргүй бий. > 6

“Бүс ба Зам” төсөл авлигаас зайлсхийж чадах уу
Төсөлд хамрагдсан ихэнх улсыг санхүүгийн ил тод байдал муу байгаа. > 10

ZGM DAILY FULL ENGLISH PAGE INSIDE > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Х.Баттулгын БНХАУ-д хийх Төрийн айлчлал эхэллээ.

МАН-ын УЗ хуралдаж, ирэх даваа гарагт намын Бага хурлаа хийхээр болов.

Тяньжинд ложистикийн үйл ажиллагаа эрхлэх хамтарсан компани байгуулаар боллоо.

Ч.Хүрэлбаатар: 2020 оноос НДС болон ЭМД-ын мөнгийг төрийн санд байршуулна.

ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын ДНБ энэ онд 7.2 хувиар өснө гэж Дэлхийн банк таамаглав.

БНХАУ-ын коксжих нүүрсний импорт өнгөрсөн онд 53 хувиар нэмэгджээ.

АНУ-д шинэ орон сууцны борлуулалт 16 сарын дээд хэмжээнд хүрч өслөө.

Топ 20 индекс лхагва гарагт 1.01 хувиар өсөж, 20035.49 нэгжид хүрсэн байна.

НИЙГЭМ

Хөдөлгөөнд оролцож байгаа гурван тээврийн хэрэгсэл тутмын нэг нь бүрэн бус байна.

Тавдугаар сарын 1-нээс ахуйн хэрэглээний усны үнийг литр тутамд нь 71 мөнгөөр нэмнэ.

Өнөөдөр орон нутаг руу явах автобусны хөдөлгөөнийг 11.00 цагаас эхлүүлэхээр болжээ.

Гар бууны тамирчин Ц.Анударь “Токио 2020” олимпын анхны эрхийг авлаа.

ДЭЛХИЙ

Д.Трамп New York Times сониныг “өвдөг сөгдөж” уучлал гуйхыг шаардлаа.

АНУ F-35 нийлүүлэхээс татгалзвал Анкара өөр улсаас сөнөөгч онгоц авахаа мэдэгдэв.

Арктикийн дулаарал хүн төрөлхтөнд доод тал нь 25 их наяд ам.долларын гарлагатай.

Toyota Land Cruiser 300-г Токиогийн авто шоу дээр танилцуулна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2018.04.25

8° | -1°

БАГА ЗЭРГИЙН ТУНАДАСТАЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658000 029112 01129

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Нефтийн үйлдвэрийн ирээдүйг дэд бүтэц шийднэ

Бид ганцхан үйлдвэр барьчихвал шатахууны гачлангаас гарна хэмээн төсөөлж ирсэн ч уг төсөл ашигтай, тогтвортой ажиллах эсэх нь түүнийг дагасан шугам хоолой, дэд бүтцээс шалтгаалах нь. Харин шинэ үйлдвэрийн хувь заяаг шийдэх энэ чухал ажлыг монголчууд хариуцаж байна. ▶12

ЗГМ: ИНФОГРАФИК



НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Сонгогчдод сонголт алга болж байна

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Хошин шогийн жүжигчин В.Зеленький Украины Ерөнхийлөгчийн сонгуульд ялсныхаа дараа Пётр Порошенкод хандаж “Таны өгсөн амлалт, хийсэн алдааны үр дүн нь би байна” гэж хэлжээ.

Украинд 2013 оноос хойш нийгэм нь талцаж, эдийн засаг нь унаж, эх орон нэгтнүүд хоорондоо буудалцаж, энгийн номхон иргэд хохирч, эх орноосоо дүрвэсээр эцэстээ ард түмэн нь залхаж “тэд л биш бол хэн ч байсан яахав” гэдэг байдлаар сонголтоо хийсэн нь улс төрийн туршлагагүй, хошин шогийн жүжигчин В.Зеленский байж таарав. Өөрөөр хэлбэл, сонголтгүй болсон ард түмэн ийм сонголт хийдэг юм байна.

2017 онд Монголд болсон Ерөнхийлөгчийн сонгуулийг та санаж байгаа байх. Түүхэндээ анх удаа дахин санал хураалтаар дүнгээ гаргасан сонгууль. Намуудын дэвшүүлсэн нэр дэвшигчдийн хэн нь ч Ерөнхийлөгчийн албан тушаалд тэнцэхгүй гэж үзэн “цагаан сонголт” буюу саналын хуудсыг хоосноор нь хайрцагт хийсэн сонгогчийн тоо 90 мянгад хүрсэн юм.

▶3

MIAT MONGOLIAN AIRLINES

ЗОРЧИГЧДЫН АНХААРАЛД

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 116 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилалтыг энэ сарын 24-26-ны өдөр зохион байгуулах болсон билээ. Тус сургуулилалттай холбогдуулан энэ сарын 25-ны өдрийн 07.00-10.00 цагийн хооронд Улаанбаатар хотын хэмжээнд автозамын хөдөлгөөнийг түр зогсоох тул тухайн өдрийн дээрх заасан цагийн нислэгүүдээр зорчих иргэд 07.00 цагаас өмнө “Чингис Хаан” олон улсын нисэх буудалд ирсэн байхыг “МИАТ” ТӨХК-аас анхааруулж байна.

“МИАТ” ТӨХК 2019 оны 4 дүгээр сарын 25-ны пүрэв гаригт Бээжин, Москва, Берлин, Сөүл, Бусан, Хонконг хотын чиглэлд нислэг үйлдэнэ.

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1273.64 0.1%	6407 1.07%	98.700 0.13%	110.70 0.12%	99.330 0.12%	2637.96	392.55	41.18

Улс төр

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгийг Төрийн санд төвлөрүүлнэ

Монголчууд 2021 онд Мазаалай бондын 600 сая, 2022 онд Чингис бондын нэг тэрбум, 2023 онд Гэрэгэ бондын 800 сая, 2024 онд Хуралдай бондын 600 сая ам.долларын өр төлнө.

С.Батсайхан / ЗГМ©

Ирэх онд инфляцыг найман хувьд барьж, түүнтэй уялдуулан цалинг нэмнэ

Г.Билгүүн
ЗГМ

Засгийн газар "Монгол Улсыг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" болон ирэх онд баримтлах төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэжээ. Мөн ирэх гурван жилд Засгийн газрын өрийг хэрхэн төлөх талаар стратегийн баримт бичгийг хэлэлцсэн байна. Энэ талаар Сангийн сайд мэдээлэл хийв.

Сангийн яам 2020 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг зургаа, инфляцын түвшинг найман хувьтай байна гэж тооцжээ. Харин гадаад худалдааны тэнцэл нэг тэрбум ам.долларын ашигтай гарна хэмээн Сангийн сайд хэллээ. Мөн тэрбээр "Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 5.1-д барьж, энэ жилийнхээс 0.3 функтээр сайжруулсан" гэв.

Сангийн яам 2020 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлд 37 их наяд төгрөгөөр 400 гаруй арга хэмжээг санхүүжүүлэх санал хүлээн авчээ. Үүнээс 10 их наяд төгрөгийн 116 арга хэмжээг санхүүжүүлэх боломжтой гэж үзэн үндсэн чиглэлд тусгасан байна. Ингэхдээ улсын төсвөөр санхүүжих арга хэмжээнд зургаан их наядыг зарцуулах санал ирсний 3.4 их наяд төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээг дэмжих боломжтой гэсэн байна. Харин улсын зардалд 3.7 их наядын санал илүүлснээс 400 тэрбумыг хасахаар тогтжээ. Эдгээр таналтыг хийхдээ гадаад өрийг төлөхтэй уялдуулах, хувийн хэвшлийн хөрөнгийг ашиглах бололцоог харж зохицуулсан аж. Мөн ирэх онд цалин тэтгэврийг инфляцтай уялдуулж нэмэх юм.

Сангийн сайдын хэлж буйгаар энэ онд хөрөнгө оруулалтыг өндөр дүнтэй тавсан учраас ирэх жил шинээр хөрөнгө оруулалтын зардалд мөнгө хуваарилахгүй байхыг эрмэлзэх аж. Үүнийг сонгуулийн жил таарч байгаа учраас хөрөнгө оруулалтын зардал үр ашиггүй зарцуулагддаг гэдгээр тайлбарлаж байна. Харин Ерөнхий сайдаас үүрэг чиглэл өгсний дагуу Байгалийн түүхийн музей, Үндэсний их театр барих мөнгийг шинэ хөрөнгө оруулалт болгож төсөвт суулгах юм. Үүн дээр өнгөрсөн болон энэ онд эхэлсэн ажлуудыг гүйцээхэд зориулж нийтдээ 1.3 их наяд төгрөг төлөвлөжээ.

Засгийн газраар хэлэлцэн баталсан нэгэн чухал шийдвэр нь "2019-2022 онд төлөх өрийн удирдлагын стратегийн баримт бичиг" юм. Энэ талаар сангийн сайд Ч.Хүрэлбаатар хэлэхдээ "2016 оны төгсгөлд Засгийн газрын өр ДНБ-ий 78.8 хувийг эзэлж байсан бол 2018 оны төгсгөлд 58.9 хувь болж буурлаа. Энэ нь барих, шилжүүлэх концессыг хийгээгүйтэй холбоотой. Ингэснээр төсвийн сахилга бат нэмэгдсэн. Үүнээс гадна ирэх онд арилжааны нөхцөлтэй гадаад, дотоод бондыг авахгүй гэсэн чиглэл барьж байна. Гадаад өрийн тухайд ирэх жил өр төлөхгүй ч 2021 оноос Мазаалай бондын 600 сая, 2022 онд Чингис бондын нэг тэрбум, 2023 онд Гэрэгэ бондын 800 сая, 2024 онд Хуралдай бондын 600 сая ам.долларыг төлөх юм. Стратегийн баримт бичгийн гол онцлог эдгээр 2.9 тэрбум ам.долларын өрийг төлөхдөө улсын төсөв, эдийн засаг, ханшид дарамтгүй байхаар зохицуулалт хийснээр онцлог" гэв.

Харин Сангийн сайдын мэдээллийн хамгийн анхаарал татсан сэдэв нь ирэх оны эхэнд Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг арилжааны банкуудаас татаж Төрийн санд төвлөрүүлэхээр шийдсэн гэсэн мэдэгдэл байв. Үүнийг эрүүл мэндийн үйлчилгээ, тэтгэвэр авагч иргэнийхээ мөнгийг эрсдэлгүй хадгалах үүднээс төр өөртөө байлгах шаардлага үүссэн гэж, сангийн сайд тайлбарлав. Энэ талаар болон ирэх оны төсөвтэй холбоотой дараах асуултад тэрбээр хариулт өглөө.

-Арилжааны банкуудаас мөнгөө татахад өөр хүчин зүйл нөлөөлж байгаа юу?

-Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын санд төсвөөс тодорхой хэмжээний мөнгө өгдөг боловч тэр мөнгө төрийн мөнгө биш шүү дээ. Иргэн, ААН-ийн төлсөн мөнгө дээрх сангуудад байршиж байгаа учраас төр эрсдлээс хамгаалах үүднээс өөртөө байлгая гэж байгаа юм.

-Ирэх жил Ирээдүй өв санд хэдэн төгрөг хуримтлуулах вэ?

-Энэ санд 2019 онд 353 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ. Мөн энэ онд Хүний хөгжил сангаар авсан өрүүдээ төлж дуусгана. Харин төсвийн хүрээний мэдэгдэлд ирэх онд 900 тэрбум төгрөгийг Ирээдүй өв санд төвлөрүүлнэ гэсэн тооцоо хийсэн.

-Уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн ханш ямар байна гэж тооцоолж байгаа вэ?

-Саяхан Сангийн яам ОУВС-гийн хаврын уулзалтад оролцож, ирэх жилүүдэд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал ямар байх талаар ярьсан. Тэндээс 2020 оны дэлхийн эдийн засаг энэ оныхоос сайн байна гэдэг нь харагдсан. Гэхдээ бид түүхий эдийн үнийг өмнөх жилүүдийнхээс бага байхаар тооцсон. Тухайлбал, нэг тонн зэсийг 6340 ам.доллар гэж тооцсон.

-Оюутолгойн далд уурхайн гэрээг цуцлах тухай ярьж эхэллээ. Хэрэв ийм байдалд хүрвэл та нарын хийж байгаа тооцоо, төсвийн хүрээний төсөөлөл талаар болох юм биш үү?

-Эрдэнэт, Оюутолгой гэсэн томоохон үйлдвэр, уурхайн ажил хэвийн үргэлжилж, улсын төсөвт өгөх мөнгөө оруулна гэдэгт итгэлтэй байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ
Монгол Улсын Төрийн тэргүүн Х.Баттулга БНХАУ-ын дарга Ши Жиньпиний урилгаар БНХАУ-д Төрийн айлчлал хийж байна. Тэрбээр ирэх өдрүүдэд Бээжин хотод болох "Бүс ба Зам" олон улсын хамтын ажиллагааны дээд түвшний хоёр дахь удаагийн уулзалтад оролцох юм.

» ЗАСГИЙН ГАЗАР
У.Хүрэлсүхийн танхим өчигдрийн хурлаараа үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх гурван хөтөлбөрийг баталлаа. Үүнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрүүд багтаж байна. Мөн "Үндэсний геомэдээллийн сан" хөтөлбөрийг таван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталжээ.

» НАМУУД
МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж, Хэнтийн нөхөн сонгуульд оролцох эсэхийг шийдэх бага хурлыг ирэх даваа гарагт хийхээр тогтлоо. Мөн хурлаар МАН-аас нөхөн сонгуульд оролцох нэр дэвшигчид хэнийг сойх тал дээр Удирдах зөвлөлийн гишүүдийн байр суурийг сонсжээ.

» ТОО
914
Зөвшөөрөл. Монгол Улсын хэмжээнд төрийн үйлчилгээ үзүүлдэг 54 байгууллага 914 төрлийн зөвшөөрөл олгож байна. Үүний дийлэнх хувь нь үйлдвэрлэл үйлчилгээний зөвшөөрөл юм.

» ХАРИЛЦАА
БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсэд Монгол Улс тээвэр, ложистикийн үйл ажиллагаа эрхлэхээр БНХАУ-тай хамтарсан компани байгуулахаар болов. Тус хамтарсан компанийн Монголын талын эзэмшил 49 хувь байх юм.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› **INFO@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ПАРЛАМЕНТ

Хурууны хээгээр бүртгэх технологи гишүүдэд цочроо өгсөнгүй

Энэ хаврын чуулганаас эхлэн УИХ-ын Тамгын газар байнгын хороо болон чуулганы ирцийг бүрдүүлэх үүднээс гишүүд хурууны хээгээр санал өгөх, ирцдээ бүртгүүлэх технологийг нэвтрүүлсэн. Харамсалтай нь гишүүдийн хуралдаан тасалж, хууль тогтоох үйл ажиллагаанд саад болдог зуршлыг өөрчилж дийлэхгүй бололтой.

Өнгөрсөн долоо хоногт ирц бүрдээгүйн улмаас эдийн засаг болон нийгмийн бодлого хариуцсан хоёр ч байнгын хорооны хурал хойшлогдсон. Мөн энэ долоо хоногт Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал ирц хүрээгүй шалтгаанаар бас л долоо хоногоор хойшлов. Эдийн засгийн байнгын хорооны хурлаар Монгол Улсын Эрдэнэсийн сангийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, орлого, гүйлгээ, зарлагын талаар хэлэлцэж, 2019 оны төсвийг нь хэлэлцэх байсан юм. Мөн Төрийн байгуулалтын байнгын хороогоор Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, төрийн зарим албан тушаалтны цалингийн хэмжээг тогтоох байлаа. [ЗГМ]

НИЙСЛЭЛ

Улаанбаатар хотыг хөрөнгө оруулагчдад сурталчлав

Өнгөрсөн долоо хоногт ГХ-ны сайд Д.Цогтбаатар, НИТХ-ын дарга Р.Дагва болон төр, хувийн хэвшлийн төлөөлөгчид АНУ-ын Флорида мужийн Майами хотод болсон блокчейн технологийн "IOHK Summit 2019" олон улсын бага хуралд урилгаар оролцжээ. Энэ салбарын дэлхийн томоохон төлөөлөл болох "IOHK"-оос зохион байгуулсан тус хурлаар "IOHK" компани Монголын финтекийн болоод блокчейн технологийн өнөөгийн хөгжлийн тухай панел хэлэлцүүлэг зохион байгуулсан аж.

Үр дүнд нь Улаанбаатар хот технологийн өөрчлөлтийн энэ эринд юу хийж байгаа, юу хийхээр төлөвлөж буйгаа танилцуулж, хөрөнгө оруулагчдад эх орноо сурталчилсан байна. [ЗГМ]

БАЙНГЫН ХОРОО

Шинжлэх ухаан, технологийн зөвлөл байгуулах төслийг хэлэлцэхийг дэмжив

Г.Билгүүн
ЗГМ

Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны байнгын хорооны хурлаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцэхийг дэмжив.

Тус хуулийн төслөөр БСШУСЯ-нд эрдэмтэн судлаачдаас бүрдсэн шинжлэх ухааны төв зөвлөл, бусад яам болон орон нутагт салбар байгуулахаар тусгажээ. Ингэхдээ улсын чанартай томоохон бүтээн байгуулалт, хөтөлбөрт ШУ, технологийн зөвлөлийн эрдэмтдийн бүтээл, саналыг тусгах бол орон нутаг дахь салбараар дамжуулан мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх юм. Харин яам бүр дээр байгуулах салбар зөвлөлийг тухайн салбарын эрдэмтдээс бүрдүүлэх аж.

Ийм зөвлөл байгуулах болсон шалтгааныг БСШУС-ын сайд тайлбарлахдаа "Эрдэм шинжилгээний байгууллагууд өөрийн судалгааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаагаас эрдэм шинжилгээ, судалгааны ажлын онол, арга зүйн хүрсэн түвшин буурах, оюуны болон материаллаг нөөц хомсдох, улмаар байгууллагын чадавх, судалгаа боловсруулалтын ажлын чанар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг бууруулахад хүргэж байна" гэж танилцуулсан юм. Мөн зөвлөл байгуулснаар төсөв шаардлагатай албан тушаалын тоо нэмэгдэхгүй гэж нэмж хэлэв.

Харин гишүүдийн зүгээс судалгаа хөгжүүлэлтийг хуульд тодорхой тусгах, эрдэм шинжилгээний ажиллагааг зөвхөн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан хийхгүй, хүрээ нь өргөн байх ёстой гэсэн санал хэлж байлаа. Мөн их сургуулийн доктор, профессоруудыг энэ ажилд илүүтэй татан оролцуулах, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэхдээ үйлдвэрлэл, практик руу ойртуулах ёстой гэв.

Тус хууль батлагдвал эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийг тогтоох зорилгоор аттестатчиллыг явуулах боломж бүрдэхийн зэрэгцээ аттестатчилал үндсэн агуулга өөрчлөгдөж, тухайн хугацаанд хийж бүтээсэн ажил, ур чадвараа үнэлүүлэх, түүндээ тохирсон зэрэг дэвийн нэмэгдлийг хүртэх боломж бүрдэх юм. [ЗГМ]

InvesCore
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Японы хөрөнгө оруулалттай Инвескор Санхүүгийн байгууллага нь байгуулагдсан цагаасаа эхлэн тогтвортой өсөлттэй байж, Монгол улсын санхүүгийн зах зээлд байр сууриа батжуулан, банк бус санхүүгийн салбарт тэргүүлэгч байгууллага болон өсөн дэвжиж байна.

Бид Харилцагч төвтэй үйлчилгээг дээдлэж, тэдэнд зөв, хариуцлагатай санхүүгийн мэдлэг, төлөвшлийг олгох чиглэлийг эрхэм болгон үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ олон улсад танигдсан, орчин үеийн технологийн дэвшлийг нэвтрүүлэгч байхыг зорин ажилладаг.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 7 салбартай, тэдгээрээр дамжуулан харилцагчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн, түргэн шуурхай санхүүгийн үйлчилгээг үзүүлж, санхүү, бизнесийн зөвлөгөө өгч байна.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ
» Санхүү, эдийн засгийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
» Санхүүгийн шинжээчээр 2-оос дээш жил ажилласан туршлагатай;
» Хариуцлагатай, ачаалал даах чадвартай;
» Англи хэлний дундаас дээш мэдлэгтэй;
» Компьютерийн хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн;
» Тогтвор суурьшилтай ажиллах сонирхолтой;
» Үнэт цаасны компанид ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Та өөрийн анкетаа info@invescore.mn хаягаар илгээнэ үү.
Зөвхөн анкетийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн кандидат руу холбоо барих болно.

ХОЛБОО БАРИХ
Утас: 7709-0077, 9004-9938
Хаяг: 13 давхар - Твин Тауэр 1, Сөүлийн гудамж 10/1, 2 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

Нийтлэлчийн булан

Албан тушаал, сайдын суудал хуваах болохоор тэд л ээлжилж суугаад байгаа атлаа Монгол Улс хөгжихгүй, монголчуудын амьдрал сайжрахгүй байгаад нийгмээрээ бухимдаж буй нь энэ юм.

С.Батсайхан / ЗГМ©

Сонгогчдод сонголт алга болж байна

Дэлхийн улс төрийн тавцанд “популизмын эрин үе” тохиож байна

◀1

Энэ бол хэний ч санаанд оромгүй үйл явдал болж байлаа. Хэрэв “цагаан сонголт” 100 мянгад хүрсэн бол дахин сонгууль зарлахаас өөр гарцгүй болох байв. Зөвхөн Ерөнхийлөгчид нэр дэвшсэн гурван хүнээс гадна ер нь л монголчууд төрийн эрхийг ээлжлэн барьсан гол намуудаас татгалзаж, шинэ хүмүүсийг гаргая гэх хандлагатай болсон нь улс төрийн барометрийн судалгаанаас харагддаг. Гол хоёр намын рейтинг нийлээд ч судалгаанд оролцогчдын 30 хувийн саналыг авдаггүй нь үүний баталгаа. Харин шинэ хүнийг гаргах ард түмний хүсэмжлэл нөгөө талаараа популистуудыг улс төрд сонгогдох хөрс нь болж байна. Бүр дэлхий нийтээрээ ийм хандлага руу явж байна гэж хэлж болно.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс төрийн тавцанд ажиглагдаж буй өөрчлөлтийг судлаачид “популизмын эрин үе” хэмээн тодорхойлж байгааг манай сонин өмнө нь нийтэлж байсан. Хойд Америк, Европын жишээг энд дурдаж болно. Өдгөө Европын улс орнуудын 60 хувь нь популист удирдагчийг сонгоод буйг Bloomberg мэдээлсэн. Хамгийн сүүлд Украины Ерөнхийлөгчийн сонгуульд улс төрийн туршлагагүй хошин шогийн жүжигчин В.Зеленьский ялалт байгуулсан бол Словакт байгаль орчны хөдөлгөөний идэвхтэн Зузана Чапутова Ерөнхийлөгч болоод буй.

Хөгшин Европ, хөрөнгөжсөн Америкийн улс төрийн тавцанд гарч буй энэ өөрчлөлт Ази тив рүү хэдийн шилжиж эхэлжээ. Ази тивд энэ онд тэрбум гаруй сонгогч оролцох хэд хэдэн томоохон сонгууль эхэлсэн. Өнгөрсөн сард тайландчууд төрийн эрхийг цэргийнхэнд өгсөн бол, Индонезид Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалт дууссан, Энэтхэгт парламентын сонгуулийн өрсөлдөөн ид өрнөж байна. Харин энэ бүх сонгуулиуд популист амлалтын эсрэг бүр том популист амлалт өгөх тактикаар болж буйг онцлон дурдъя.

Өөрийгөө эх оронч хэмээн өргөмжилсөн улстөрчдийн олон улсын нэршил нь популистууд. Сүүлийн үед монголчууд “поп” хэмээн нэрийдэх болсон. Уг нь энэ бол эстрад урлаг дотроо олон нийтэд хамгийн их таалагддаг урсгалын нэр л дээ. Хэмнэл нь хөнгөн, хөгжим нь аялгуулаг учраас чихэнд сонсголонтой, бас аялахад амархан. Тиймдээ ч Элвис Пресли, Битлз зэрэг хамтлаг, дуучид гарч ирсэн 1960-аад оноос хойших дэлхий нийтийн хөнгөн хэмнэлтнүүд оршиж байсан үе бүртээ бусад урлагийн зүтгэлтнүүдээс илүү алдар хүндтэй бас ашиг орлоготой байсаар ирсэн юм. Харин манайд бол улс төрийн попчид нь урлагийнхнаасаа илүү алдартайн дээр олон нийтэд таалагдахдаа ч хурдан болж.

• Хөгшин Европ, хөрөнгөжсөн Америкийн улс төрийн тавцанд гарч буй энэ өөрчлөлт Ази тив рүү хэдийн шилжиж эхэлжээ.

• МЕС-ийн судалгаагаар “Топ 10”-ын найм нь “поп” хэмээгддэг улстөрч байсан гээд бод доо.

• Төрийн ордонд сууж, их улс төрд намуудыг төлөөлдөг хэсэгт бараг л үе солигдолгүй 20 жил өнгөрсөн байна.

Хэдхэн хоногийн өмнө МЕС судалгааны байгууллагаас хийсэн улстөрчдийн чансаа тогтоох санал асуулгын дүн гарсныг танилцуулав.

“Топ 10”-ын найм нь “поп” хэмээгддэг улстөрч байсан гээд бод доо. Ерөнхий сайд У.Хүрэлсүх уг судалгааг тэргүүлсэн бол Ерөнхийлөгч Х.Баттулга аман хүзүүдсэн байна. Иргэд рейтинг өндөртэй улстөрчөөр С.Ганбаатар, С.Жавхлан, Ж.Батзандан, Н.Энхбаяр, Л.Оюун-Эрдэнэ нэмээд Буянгийн Жагаа (Б.Жаргалсайхан) нарыг нэрлэсэн байна.

Эдгээр хүмүүсийн олон нийтийн дундах нэр хүнд улс төрийн гол хоёр хүчин болох МАН, АН-аас өндөр байгаа нь ч маргашгүй үнэн. Гэвч популист улстөрчдийн нэр хүнд өсөх тусам Монгол Улсын нэр хүнд унаад байдаг урвуу хамаарал байгаа нь бас үнэн юм.

Гэхдээ төрийн эрхэнд гарч буй популистууд, тэднийг сонгож буй сонгогчдын буруу биш. “Ирэх сонгуульд хэнд саналаа өгөх вэ гэсэн асуултад “Ёстой сонгох хүн алга. Гэхдээ нэг нь л гарах хойно шинэ хүнд өгдөг юм уу” гэсэн хүн олон байна.

Яагаад гэвэл Төрийн ордонд сууж, их улс төрд намуудыг төлөөлдөг хэсэгт бараг л үе солигдолгүй 20 жил өнгөрсөн байна. Үнэндээ доогуураа, анхан шатандаа л АН, МАН гэж талцаад байгаа болохоос дээгүүрээ бол хэтэвч, эрх ашгаараа салахын аргагүй болсон хэдхэн хүн л Монголын улс төрийн өнгийг тодорхойлж, өрмийг хамсаар явна.

Улиг болтлоо сонгогдож, даргын суудал хуваах бүрт дараалллын эхэнд томилогддог тэдгээр хүмүүс өөрсдийгөө нэгдүгээр эгнээнийхэн гэж нэрлэдэг. Тэднийг улс төрд удлаа гэж хэн ч уурладаггүй. Туршлага, мэдлэг нь хэрэгтэй. Харин албан тушаал, сайдын суудал хуваах болохоор тэд л ээлжилж суугаад байгаа атлаа Монгол Улс хөгжихгүй, монголчуудын амьдрал сайжрахгүй байгаад нийгмээрээ бухимдаж буй нь энэ юм. Шинэ хүн ороод ч шинэчлэгдэхээ нэгэнт өнгөрсөн гэж АН, МАН-ыг харж байгаа хэсэг ч бий. Тиймээс цоо шинэ хүнийг олон нийт хүсэж байна.

Шинэ хүн ороод ч шинэчлэгдэхээ нэгэнт өнгөрсөн гэж АН, МАН-ыг харж байгаа

Дээр хэлсэнчлэн “Тэд л биш бол хэн ч байсан яахав” гэх байдлаар сонголтоо хийтэл нь нийгмийг бухимдуулсан “өвгөн кадрууд” Монголын улс төрийн орон зайг популистууд эзлэхэд хүргэсэн нь маргашгүй үнэн. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА

УЛААНБААТАР ХОТЫН БАНК
20 жил
Үндэсний үйлдвэрлэлийг дэмжигч банк

“ШИЛДЭГ ОЮУТАН - 2019”
ТЭМЦЭЭНИЙ ЯЛАГЧ ТОДОРЛОО

СЭЗИС-ийн зохион байгуулдаг “Шилдэг оюутан - 2019” реалити тэмцээн долоо дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Улаанбаатар хотын банк нийгмийн хариуцлагын хүрээнд тус тэмцээнийг дэмжин ажилласан юм. Монгол улсын гэрэлт ирээдүй болсон шилдэг оюутнуудаа хийж бүтээх их үйлсэд нь амжилт хүсье!

info@ubcbank.mn   1800 1800   www.facebook.com/ubcbank

Судлаачийн үг

Ядуурч, гуйлгачилсан нь өөрөөс минь боллоо гэдэг монгол хүн би хараагүй

Олхонуд Баярхүү
профессор

ЯДУУРЛЫГ ТАШУУРДАГЧ

Хэний ч мэдэх, хэн ч хүлээн зөвшөөрөх, нүднээ ил байгаа баримт. Би өөрөө социалист, капиталист хоёр нийгмийн бүтээгдэхүүн учраас ингэж зориглон хөндөж байна л даа. Ардчиллын дуун цуурайтсан 1990 оноос өнөөг хүртэл чилийсэн 29 жил өнгөрчээ. Гучин жил гээд ерөнхийлөөд авчихъя. Тэгвэл өнгөрсөн 30 жилд ардчилсан шинэ нийгмийн буянаар Монгол Улс хөгжсөн үү гэвэл хөгжсөн, ядаж ДНБ-ээ аваад үз. Социализмын үед СССР ба социалист ах дүү орнууд нийлж, албадаж ажиллуулаад ч ДНБ тэрбум ам.доллар хүрч байгаагүй юм. Тэгвэл одоо 10 тэрбумыг хэдийн давсан. Хэрэв Ю.Цэдэнбал гуайг амилуулан босгож ирээд харуулбал юу харагдах вэ. Шиль толь болсон олон давхар барилгууд, гудамжаар дүүрэн хөлхөх барууны машинууд (нэг ч орос машин байхгүй болтлоо), Цэдэнбалын өөрийнх нь хүсээд, албадаад ч 25 сая хүрдэггүй байсан мал сүрэг нь 70 сая болчихсон. Энэ чинь хөгжил биш гэж үү.

Хувь хүн дээр аваад үз. Хувийн хувьчлагдсан нийгэм Монголд байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Өөрсдөө л төрдөө даатгуулах гээд үхэлдээд байгаагаас бус энэ их хот, хөдөөгөөр өдөр бүр холхиж явдаг монголчууд бол бүгд л хувийнхаа ба гэр бүлийнхээ ажлыг хөөцөлдөж явдаг юм шүү дээ. Тэд бол хувийн өмчтэй, үл хөдлөх хөрөнгө болох байртай, газартай, хашаа байшинтай, малтай, машинтай, хүссэн улс руугаа аялдаг гадаад паспорттай (иргэн бүр), хүссэн гадаад орондоо ажиллаж, сурч, эмчлүүлдэг. Хөдөөнөөс хот руу дураараа шилжин ирээд ажиллаж, амьдрах боломжтой. Гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх нь нээлттэй. Ажлын байрууд үй түмээрээ бий болсон. Ажлын байрны зарууд өдөр тутам, цаг тутам ажиллагсдаа урин дуудаастай! Юу нь дутлаа гэхэв.

Эсрэг аргумент. Монголчууд яагаад ядуу байдаг вэ. Яагаад гурван хүний нэг нь мөнхөд ядуу гэх им тамгатай явдаг юм бэ. Гучин жил ардчилал шинэчлэл хийчихээд гуравны нэгийгээ ядуу байлгаад байдаг ямар увидас монголчуудад байна вэ. Төрийн бодлого нь уу, эсвэл ард иргэдийнх нь сайрхан яриад байдаг “монгол ухаан”-ы ид шид үү. Эсвэл нүүдлийн соёл иргэншлийнх нь XXI зууны нэг хувилбар уу.

Дэлхий нийт, манай хөрш, түнш, хандивлагч бүх улс орон яг иймасуултын өмнө тулж ирчихээд байна. Манай эх оронд иргэний дайн, гадны зэвсэгт халдлага, шашин, угсаатны мөргөлдөөн болоогүй, өлсгөлөн, өвчин тахал, байгалийн гэнэтийн аймшигт осол гамшиг тохиогоогүй байтал ард түмэн нь ядуураад байдаг. “Увидас” гэж үүнийг л хэлэх гээд байна. Хашилтад авчихъя.

Гучин жилд гадаад улсуудаас өгсөн, тусалсан, хандивласан, зээлсэн, зээлснийг нь хүчингүй болгосон, монголчууд авч хэрэглэсэн, хэрэглэсээр байгааг нь мөнгөн дүнгээр тооцож гаргаад гурван сая хүнд нь хуваагаад үзээрэй. Нүднээ итгэмгүй тоо гарна.

Яасан бэ тэр их мөнгө? Бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, орлогын бодит өсөлт гарсан уу. Энэ их мөнгө яг хэрэг болсон уу, яагаад өсч үрждэггүй юм бэ гэх асуулт гадаадын харилцагч нараас байнга тулгаастай. Тэгэхээс тэгэх гэж хор шарандаа ядуу суугаад байдаг юм уу.

Монгол Улсын хэмжээнд 1.2 сая иргэн хөдөлмөр эрхэлдэг гэсэн албаны тоо байдаг ч би лав 100 хувь итгэдэггүй. Дээрээс нь би амны уншлага болгочихоор бардам хэлдэг дээ. Юу гэвэл өнгөрсөн 30 жилд ард түмнээрээ ажил хийлгэж чадсан ганц ч Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, ганц ч Засгийн газар, ганц ч УИХ байгаагүй. Хойшид энэ янзаараа бол гарч ирэх ч үгүй. 2020 оны сонгуулийн дараа дахиад 1/3 нь ядуу, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа дахиад 1/3 нь ядуу, 2024 оны сонгуулийн дараа ч байдал ялгаагүй. Хэрэв нийгмийн халамжийн бодлого явуулахгүй бол тал нь ядуурахад ганцхан хуруу дутуу.

Ядууг оролцуулаад тарчиг, өртэй, мөнгөтэй хэрнээ гундуу, уур уцаартай бүх монголчуудад “Та нар буруугүй, улстөрчид л буруутай, жишээ нь тэр тэр” гээд шууд нэр заахтай зэрэг дайсан нь тодроод ядарсан ард түмэн цайрч цагаараад ял дуудаад эхэлдэг.

Өөрийнхөө сайн, мууг хүн өөрөө л үүрэх ёстой. Гэтэл монголчууд бусдад нялзаадаг араншинтэй. Ядуурч, гуйлгачилсан нь өөрөөс минь боллоо гэдэг монгол хүн би хараагүй.

Ажилгүй, завтай, сул дэл хүнд ёдрын бодол орж ирнэ гээч. Зах зухаас нь дуулгая. Өнгөрсөн 30 жилд улс төрийг авч явагсад МАНАН гэж нэг лут хаягтай болчихсон. Тэд нь Монгол орныг тонон дээрэмдсэн. Тэдний бүх булайг Монголын ард түмэн яс махандаа хүртэл ойлгож авсан. Одоо эх орноо аврахын тулд өшөө авах, хорслоо тайлах ганцхан зам л үлдсэн хэмээн захын иргэн амны уншлага болгох нь холгүй. Цайлган цагаан ядарсан ард түмнээ мөлжиж хөлжсөн баячуудаас цусан өшөө авахыг улс төр нь бараг уриалан дууддаг гэхэд хилсдэл болохгүй. Нийтээрээ дайсны эрэлд явж байхад дайсныг нь улстөрчид нь заагаад өгчихлөө. Тэр дайсандаа дайн зарлаад дайтаад байдаг. Одоохондоо хэвлэлийн коментоор л дайтаж байна. Цаашдаа яах бол.

Социологийн зарим судалгаагаар Монгол орон өнгөт хувьсгалын яг босгон дээр, баялгаа барж идээд өлсгөлөнд нэрвэгдсэн “Азийн Венесуэл” болохын зам дээр байна. Монгол оронд өнгөт хувьсгал дэгдэнэ гэж би ёрлож байгаа юм биш. Хэзээ хэрхэн дэгдэх өдөр судрыг мэргэлдэг нь биш. Гэхдээ энэ их ядуурал, нийгмийн тэгш бус байдал, социал ялгарал, үзэн ядалт дээр ганцхан цучил хийгээд чүдэнз зурахад л гал оволзоод явчихна. Хэрэв тэгж босч тэмцвэл манай улсын хууль хүчний байгууллагууд ёстой нэг барьц алдана. Шалтаг л хүлээгээд байгаа юм шиг надад санагддаг. Хятадуудын эсрэг албан ёсны ноцтой том зэмлэл, УИХ-аар ШХАБ-д жинхлүүлэхээр санал хураах, төрийн түшмэдийн хэн нэгэн нь жирийн иргэнд халдаад амийг нь сүйтгэчихвэл, эсвэл жагсаал цуглааныг тараах гэж хүч хэрэглэн цус урсгавал, олон хоногоор зам хаавал, гэр хорооллыг хүчээр буулгах гэвэл гэх мэт маш олон шалтаг. Хэрэв аль нэг нь л тохиовол тэсрэлт гарахад тун ойртсон мэт ёр надад буудаг. Тохироо ч бүрдсэн л дээ.

Үй олон ядуус, ноорхойчууд, өртөнгүүд нийгмийн хүч хэрэглэсэн хувьсгалын хөдөлгөгч хүч байсныг (Киргизэд хоёр удаа, Украин, Гүрж, Арабын орнуудад гэхчлэн харуулсан) манай улстөрчид огт санаж мэдрэхгүйгээр поподож байна. Өөрсдийг нь мөдхөн хөнтөрч хаяад ял дуудан шившиглэнэ гэдгийг мэдэхгүйгээр өмнөхүүдээ харлуулж яллаад, хураагаад, баривчлаад байвал цагаадна, дахиад ялчихна гэсэн бөөн итгэл сэтгэл.

Нэгэнтээ хүн амын тал нь улс төрийн эсрэг, улстөрчдийн эсрэг, 1/3 нь үгээгүй ядуу, ядуугаасаа болж хар мөртэй байх аваас төрийн ордонд суугаа, яамдад суугаа аль намын хэн ч тэдний хувьд дайсан нь. Өмнөх ба одоо гэж ялгахыг хувьсгалын хөдөлгөгч хүч хар масс хүсэхгүй.

“Улстөрчид буруутай, та нар буруугүй ээ” гээд буугаад өгөхтэй зэрэг ерөөсөө төр засгийн ажил алба ч явахаа больчихно. Төрийн бүх албан хаагчдыг бүгдийг нь хулгайч гэж үзнэ. Гудамжинд дүрэм зөрчсөн нэг приусийг цагдаа зогсоогоод торгууль бичихэд цаад жолооч учиргүй уурлан “Ядарсан ард түмнээ дээрэмдлээ” гээд бөөн хэл ам хийгээд гудамж дүүрэн хэрүүл хараал. Тэр цагдааг жолооч нар бөөрөлхөж алах дөхөж байна лээ. Бүр цагдаагийн байгууллага ч ажлаа хэвийн явуулж болохгүй болж таарлаа. Би зам дээр харснаа л бичиж байна. Цааш нь эрүүгийн гэмт хэргүүд, ялангуяа ахуйн хулгай, залилан, халаасны хулгай, дээрэм хийгчид ял сонсохтой зэрэг улстөрчид рүү буруугаа чихчихээд хэргээ хэрэгсэхгүй болгохыг шаардах юм биз. иймбайдал үүсэхэд ганцхан хуруу үлдсэн шүү.

Гуравхан сая хүндээ ахдахаар олон лам, бөө, үзмэрч, удган, мэрэгч төлөгч байна

“Та нар буруугүй ээ” гэдгийн хариуг мөн ч олон хувилбараар төсөөлж болж байна. Нэгэнтээ улстөрчид нь олигархитайгаа нийлээд гударчихсан тул цайлган цагаан ядарсан ард түмэн нь дээдсээсээ мөнгө тавьж олгохыг шаардаж, болохгүй бол дээрэмдэж авах ёстой гэхийн наагуур байна. “Ард түмэн чинь ядуу байна” гээд Ерөнхий сайд нь төрийн түшмэдээ заналхийлчихсэн тул одоо төрөөсөө мөнгө нэхээд байх нь тэр. Хураагдаж буй үй олон лицензийн сураг гарч, түүний цаана багширсан их мөнгө ядарсан ардын нүднээ буулаа. Тараах өдөр судрыг ард иргэд нь тэсэн ядан хүлээнэ. Салхитын мөнгөний орд руу ЗГХЭГ-ын дарга нь ахлаад лиценз хураах ажиллагаа явуулж, зурагтаар баахан харуулсан. Салхитын мөнгөний ордын хураагдсан мөнгөнөөс Цагаан сарын өмнө хөгшчүүдийн тэтгэвэрт нэмж өгөхгүй юм байх даа хэмээн манай хамар хашааны нэг хөгшин ярьж байсныг би жишээлж, эрх баригчдад хүргэж байна.

Ажил хөдөлмөр эрхлэх, ажлын бүтээлээр мөнгө босгохын эсрэг, төр нь мөнгө хуримтлуулахын эсрэг зан үйл, ажил үйл Монголд дэндүү олон. Монгол орныг ил бус, далдуур сөхрүүлдэг явдлуудыг нэрлэе.

Улс даяараа баяр ёслол тасрахгүй, тасраахгүй янзтай. Шинэ жилээ нижгэр тэмдэглэж байна. Залгаад Цагаан сар, Мартын 8, Эр цэргийн баяр, гавьяатын найр, одонгийн найр, наадам, аймаг сумдын наадам, бүсчилсэн наадам шил дарна. Амралтын өдрүүд нь урт гэж яана. Долоо хоногоор нь амраах тохиолдол энгийн үзэгдэл. Баярлах болохоороо ядуурал нь алга болчихно. Бүх айл өрх, бүх хамт олон, ард нийтээрээ баярлана. Зурагтын дэлгэц уйдахааргүй. Ажил хэрэгч, бизнесийн, мэдээ мэдээллийн, эрдэм түгээх нэвтрүүлэг алга болчихно. Хувьдаа хөл дүүжлэх машинтай, гэр байшингаа хувьдаа авчихсан, гэртээ зурагт хөргөгчтэй, өлөн хонодоггүй ийм ард түмэн өөрсдийгөө ядуу гээд төрдөө туниад, төрөө сөхрүүлэх гээд байгааг би ямар нэг хорлол юм болов уу гэж үздэг.

Монгол орныг далдуур сөхрүүлдэг зүйлүүдийг ичихгүй нэрлээд байя. Шагналын тогтолцоо гэж нэг гаж юм Монголын нийгэм, хүн ардыг ямагт үймүүлж, талцуулж, сэтгэхүйг нь эвдэж, хийж бүтээхийг сарниулж байна. Насанд хүрсэн хүн болгон “Алтан гадас”-тай байх ёстой гэсэн мухар сүсэгт автсан. Одон медаль, цол хэргэм, өргөмжлөл, элдэв гуншин Монголын нийгмийг дарсан. Гавьяат өгөхгүй бол үхлээ гэж төрдөө туньсан 17 мянган хүний өргөдөл ЕТГ-ыг дарчихсан. Ерөнхийлөгч П.Очирбатын үеэс тооцвол гавьяат өгсөөр, сугарч хоцорсоор өгөгдөөгүй гавьяатын өргөдөл 43 мянга (нөгөө ертөнц рүү явж одсон нь маш олон) байна гэнэ лээ. Хүн амын 1/3 нь ядуу Монголын “гавьяатын гайхамшигт үлгэр” явж явж энэ. Одон медаль, цол хэргэм, өргөмжлөл хүртэхийн тулд л монгол хүн ажил хийчээн болдог юм биш үү.

Монгол орныг ил бус, далдуур сөхрүүлдэг явдлуудаас миний онилж шүүмжилдэг нэг үзэгдэл бий. Ажиллаж хөдөлмөрлөхийг нь сатааруулсан, сарниулсан, сэтгэхүйг нь олон тийш татаж үймүүлсэн шоу цэнгүүн, концерт, зугаа цэнгэл дэндүү олон, ар араасаа угсраад л. Ард түмнээ сэхээ авах завдалгүйгээр дуу хуур, урлаг, уран сайхнаар бөмбөгдөөд байх нь тэр. Гуравхан сая хүндээ ахдахаар олон лам, бөө, үзмэрч, удган, мэрэгч төлөгч, гэгээнтэн, шидтэн, нийтийн дуучин, хошин урлагийнхан, солонгос сериал түгээгчид, сүлжээчин байна. Тэднийг дагасан нийгмийн маш том салбарууд байдаг ба тэднийг дагаж намирсан, наргисан, тойрч нягтарсан, омогшсон олон зуун мянган хөгжөөн дэмжигчтэй. Гэм нь тэр салбарууд нь Монгол Улсын сан хөмрөгт ганц ч төгрөгийн ашиг өгдөггүй, улсын төсөвт нэмэр болдоггүй. Хөгжөөн дэмжигчид нь бүтээлч хөдөлмөрийн алтан цагаа дэмий үрдэг.

Монгол орныг ил бус, далдуур сөхрүүлдэг дээд боловсролын тогтолцоо ёстой нэг алж байна аа. Гадаад улсад боловсролын тогтолцоо нь онц сургахыг (зөвхөн дүн), олимпиадад түрүүлэхийг, нийгмээрээ дээд боловсролтой болохыг дэмждэггүй. Амьдралд арчаатай, ажилч хөдөлмөрч, нийгэмч, зөв хүн байхыг сургадаг бол Монголд зах зээлийн нийгэмд өөрийгөө бэлтгэх талаар хичээл дадлага огт олгодоггүй. Хувь, хувьсгалын их дээд сургуулийнх нь тоо хэтрээд, төгсөгчдийнх нь 70 хувь ажилгүй үлддэг. Улсаараа, нийслэлээрээ дүүрэн дипломтой, эцэг эхээ мөлжсөн дээд боловсролтнууд.

Монгол орныг ил бус, далдуур сөхрүүлдэг зүйлд бүтээгээгүй, хөдөлмөрлөөгүй байхад нь төрөөс халамжийн бодлого хэрэгжүүлдэг, бэлэнчлэх сэтгэлгээг хөхиүлдэг практикийг нэрлэж байна. Хийж бүтээдэг гадаад улсад бол халамжийн бодлогыг онцгой тусгай шаардлагаар (эрүүл мэндийн аргагүй байдал, эсвэл гавьяаны амралт гэх мэт) жинтэйхэн хүртээдэг бол Монголд халамжийн бодлогыг бүтээсэн, бүтээгээгүй, хөдөлмөрлөсөн, хөдөлмөрлөөгүй ялгаагүй бүгд хүртэх давуу талтай. Гэм нь бэлэнчлэх сэтгэлгээ нийгэмд нь гүн суусан. Монголын захын иргэн төр засаг биднийг тэжээх ёстой гэсэн сэтгэлгээтэй. Халамжийн бодлого тийм сэтгэхүйг нь байнга хөөргөдөж өгдөг.

Монгол орныг ил бус, далдуур сөхрүүлдэгт гадаадад байгаа монголчуудаас орж ирдэг мөнгөний их урсгал орно. Солонгост дөчин хэдэн мянган монгол хүн байна хэмээн бахархалтай ярихыг бишгүйдээ сонсдог. Тэд бол дор бүрнээ Монгол дахь аав ээж, ахан дүүсээ ажил хийлгүүлэхгүйгээр тэжээн тэтгэгчид юм. Ганц Солонгос гэлтгүй ертөнцийн өнцөг булан бүрээс Монгол руу мөнгө цутгаастай. АНУ-д америк иргэнтэй гэрлэсэн монгол бүсгүй Монгол руу мөнгө илгээдгээ нөхрөөсөө тас нуучихсан, сарын цалингаа багасгаж хэлж ойлгуулчихаад банк руу нууцаар шогшоод л. Герман, Британи, Франц... хаана л бол иймүзэгдэл түгээмэл. Нэгэнтээ сар бүр, тогтсон хугацаанд гадаадаас мөнгөн илгээмж ирээд байх юм бол ерөөсөө ажил хийж биеэ зовоож яах юм бэ. Ард нь Монгол эх орон маань босч өндийхгүй байна гэдгийг ухаарах сөхөө байгаад ч яах юм, идэж ууж хэрэглэж л байвал.

Үүнээс гадна улс төрийн гаж тогтолцоо, олон намын систем бол чухамдаа хөгжлийн чөдөр юм. Нам дагасан хүн сүрэг нэгэнт бий болжээ. Сүргийн гишүүний мэдлэг чадвар, боловсрол чухал биш. Гэхдээ тэд хүссэн тушаалдаа очихдог учраас дэлхийн боловсрол өвөртөлж ирсэн нэр төртэй залуус ой нь гутаад эргээд гадаад руугаа алга болдог гашуун түүхийг нэрлэе.

Өнөөгийн Монголд популизм л хөгжөөд байгаагаас ажил хийх, ажлаа үнэнчээр хийх сонирхол иргэдийн дунд бараг үгүйтэй адил. Ерөөсөө ажил хийгээд яах юм. Улстөрчид нь мөнгө олж өгөөд байх юм бол зүгээр авч хүртчихээд, идээд, хэрэглээд, үрээд байхаас өөр яах юм. Өгөхгүй бол УИХ-д сонгохгүй, тэгэхээр өгч л таарна. Зүй тогтол нь яг ийм юм.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

8 658000 029112 001129

Би үйлдвэрлэгч

Приус машины батарей сэргээх Монгол дахь анхны үйлдвэр

Нөхөн сэргээсэн батарейндаа зургаан сарын баталгаа өгдөг

Г.Санжааханд
ЗГМ

Нийслэлийн замын хөдөлгөөнд оролцож буй автомашины дунд приус багагүй хувийг эзэлдэг. Тэгвэл Улаанбаатарт анх удаа приус машины батарей нөхөн сэргээх лаборатори үйлдвэр байгуулагджээ. “ДЦС-III”-ын хойно байрлах “Форвард Моторс” ХХК-ийн авто үйлчилгээний төвд байрладаг уг үйлдвэрийг “Би үйлдвэрлэгч” буландаа онцоллоо. Цаашид зөвхөн приусээр хязгаарлахгүй, гибрид хөдөлгүүртэй бүх төрлийн машины батарейг нөхөн сэргээх зорилт тавьжээ. Тус үйлдвэрийн талаар “Форвард Моторс” ХХК-ийн ерөнхий захирал Г.Орхонтуяатай ярилцлаа.



Япон улсад хэрэглэхээ больсон нэг машины батарейнаас 7-9 ширхэг модулийг дахин ашиглах боломжтой гэсэн тооцоолол гарсан байна. Гэтэл манай улсад 1-2, зарим батарейнаас нэг ч модуль гардаггүй.

Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

-Манай улс анх удаа батарей нөхөн сэргээх үйлдвэртэй болсон байна. Үйлдвэрийнхээ талаар мэдээлэл өгөхгүй юу?

-“Тоёота” Корпорацын дэмжлэгтэйгээр Дэнсо корпорацид боловсруулсан технологид үндэслэн гибрид батарейг нөхөн сэргээх үйлдвэрийг Монголдоо байгууллаа. Судалгаа хийж үзэхэд Монгол Улсад 150 мянга гаруй приус загварын автомашин байна. Тиймээс энэ үйлдвэр манай улсад ашигтай ажиллах бүрэн боломжтой. Эдгээр машины гибрид батарейг Япон улсад 10 гаруй жил хэрэглэсэн байдаг учир манай улсад орж ирээд 5-6 жил болоод муудчихдаг. Японоос нөхөн сэргээх батарей авах гэхээр зардал их байдаг. Тиймээс иргэдийн эрэлт дээр үндэслэн “Тоёота” автомашинтай хэрэглэгчдэд зориулж гибрид батарейг нөхөн сэргээх үйлдвэрийг байгуулсан. Манай үйлдвэрийн хувьд “Дэнсо” корпорацын хилийн чанадад байгуулсан анхны үйлдвэр.

Япон нөхөн сэргээсэн батарей манай улсад зарагддаг. Гэхдээ тухайн батарейг Японд нөхөн сэргээгээд наашаа нь авчрах хугацаанд цэнэгээ алдана. Тиймээс тухайн газар нь хийвэл ашиглалт сайн байдаг. Үүнээс гадна цэнэг алдсан тохиолдолд дахин сэргээх боломжтой.

-Батарейг хэрхэн нөхөн сэргээдэг тодорхой тайлбарлахгүй юу?

-Хүмүүс өөрийнх нь машинд байгаа батарейг шууд цэнэглэнэ гэж ойлгоод байгаа юм. Тийм биш. Приус автомашины батарей 28 модулиас бүрддэг. Нэг батарейг зургаан үзүүлэлтээр шалгаж үзнэ. Хэдэн ч модуль эвдэрсэн байж болно.

Манай улсад нэг батарейнаас 1-2 модуль гардаг

Солих шаардлагатай модулийг бусад модультай ижил үзүүлэлтээр тэнцвэржүүлээд угсардаг. Дараа нь төхөөрөмж дээр угсарсан батарейны цэнэгийг нь алдуулаад буцааж цэнэглэн ажиллагааг нь тогтворжуулна. Ингэснээр найдвартай ажиллагаатай батарей болж байна гэсэн үг. Түүнээс биш вольтоор нь хэмжээд, энэ батарей нурсан бусад нь зүгээр гээд өөр батарей хийвэл жаахан яваад л алдаа гардаг. Ингэж нэг, хоёроор нь солилоо гээд үр дүнгүй.

-Хүмүүст нэг, хоёроор нь солих хямд тусдаг байх. Батарейгаа бүхэлд нь нөхөн сэргээлгэхэд хэд орчим төгрөг зарцуулагдах бол. Үнийн хувьд ялгаа бий юу?

-Батарейг бүхэлд нь шалгахад нэг өдрийн ажил болдог. Тухайн хүн машинтайгаа ирж, ажлын хөлсөө төлөөд батарейгаа шалгуулан ашиглаж болох нь хэд байна гэдгийг мэдэж болно. Тухайлбал, арван модуль нь зүгээр байлаа гэхэд буцаан угсраад үлдсэнийг нь хийж болдог. Гэхдээ батарей нь бүхэлдээ ашиглаж болохооргүй болсон тохиолдолд цаг болон мөнгөний гарз болно. Ийм тохиолдолд бүхэлд нь сольсноос ялгаагүй өртөгтэй байдаг. Бүхэлд нь солиход 800 мянган төгрөг байдаг юм.

-Хүмүүсийн ашиглахаа больсон хуучин батарейг яадаг вэ?

-Япон улсад хэрэглэхээ больсон нэг машины батарейнаас 7-9 ширхэг модулийг дахин ашиглах боломжтой гэсэн тооцоолол гарсан байна. Гэтэл манай улсад 1-2, зарим батарейнаас нэг ч модуль гардаггүй. Тиймээс бүхэлд нь сольж байгаа юм. Яагаад гэвэл стандартын бус завсар буюу зөвхөн вольтоор нь үздэг. Сайн вольттой хэрнээ хэрэглэж болохгүй батарей байж болно. Батарейгаа бүхэлд нь биш нэг нэгээр нь сольсон тохиолдолд зүгээр байсан модулийг муутгадаг учир дахин ашиглах боломжгүй. Тиймээс хэрэггүй болсон батарейг нэгдсэн байдлаар цуглуулаад Япон руу гаргадаг. Одоогоор гурван контейнер гарсан байгаа. Зарим хүн хуучин батарейгаа өгөхгүй гээд аваад явдаг.

-Хуучин батарейгаа Япон руу явуулдаг нь ямар учиртай юм бэ?

-Гибрид батарей нь дотроо никель, алт гэх мэт олон нарийн бодистой. Тэр болгоныг нь ялгаж аваад устгалд оруулан түүхий эд болгож дахин үйлдвэрлэдэг. Хог хаягдлаа үлдээхгүй гэдэг утгаар Япон улс руу буцаан гаргаж байгаа юм.

-Өмнө нь нөхөн сэргээсэн батарейгаа турших үзсэн байх. Туршилтаа хэдий хугацаанд хийсэн бэ?

-Такси үйлчилгээ эрхэлдэг зургаан машинд тавьж, хоёр жилийн хугацаанд туршилт хийсэн. Өдөрт 150-200 км явдаг. Энэ хугацаанд ямар нэгэн асуудал гараагүй. Бид нөхөн сэргээсэн батарейндаа зургаан сарын баталгаа өгч байгаа.

-Зөвхөн приус машины батарейг нөхөн сэргээх юм уу. Цаашид хэрхэн өргөжих вэ?

-Цаашид гибрид батарейтай бүх төрлийн машины батарейг нөхөн сэргээнэ. Одоогоор судалгаа, шинжилгээний ажил хийж байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

II улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна



Онлайн захиалга

- Улиралд: 5000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 10 000₮ (124 дугаар)
- Жилд: 15 000₮ (248 дугаар)

Хэвлэмэл захиалга

- Улиралд: 30 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 60 000₮ (124 дугаар)
- Жилд: 120 000₮ (248 дугаар)

Хосолмол захиалга

(Хэвлэмэл + Онлайн)

- Улиралд: 32 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 65 000₮ (124 дугаар)
- Жилд: 125 000₮ (248 дугаар)

tdbpay

Та доорх QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт **и-мэйл хаяг, утасны дугаараа** бүртгүүлэн Засгийн газрын мэдээ сониныг өөрийн хүссэн хэлбэрээрээ захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:

УЛААНБААТАР ХОТЫН БАНК

2600092954

тоот дансанд мөнгөө тушаана уу.

zgm.mn ZGMmn zasagco zgm.mn 70103131 99903581

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Улс хоорондын шуудангийн бүртгэл, хяналт, лавлагааны U post системийн үнэлгээг хийж, шинэчлэх, хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь одоо ажиллаж байгаа улс хоорондын шуудангийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг хэрэглэгчдэд нийцүүлэн нэмэлт хөгжүүлэлтийг хийж, боловсронгуй болгоход оршино.

2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх компани нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн баталгаажсан хуулбар болон дэлгэрэнгүй танилцуулга
- Мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөц, тоног төхөөрөмж, ажлын байр, эргэлтийн хөрөнгийн хүрэлцээтэй эсэхийг нотлохтой холбоотой дэлгэрэнгүй тайлбар, танилцуулга.
- Шуудангийн бүртгэлийн системтэй ижил төстэй ажил хийж байсан туршлагын талаарх мэдээлэл.
- Ижил төрлийн ажлын туршлагын талаарх мэдээлэл /Сүүлийн 2 жил/
- Компанийн санхүүгийн тайлан /Сүүлийн 2 жил, аудитаар баталгаажсан байх/
- Монгол улсын татвар, шүүхийн байгууллагын тодорхойлолт

3. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2019 оны 04 дүгээр сарын 25-аас 05 дугаар сарын 01-ний өдрийн 09:00-17:00 цагийн** хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 12:00 цагаас** өмнө ирүүлнэ үү. Ирүүлсэн мэдүүлэгт үндэслэн саналын урилга болон ажлын даалгаврыг хүргүүлэх зөвлөхийн хураангуй жагсаалтыг гаргаж Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудсаар зарлана.

Хаяг: Харилцаа холбооны зохицуулах хороо, Метро бизнес төв, А-блок, 5 давхар, Д.Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг, УБ 14201-0033, Утас: 304258, Цахим хуудас: www.crc.gov.mn, Цахим шуудан: info@crc.gov.mn

Мөнгөний урсгал

О.Агиймаа
ЗГМ

Монголын хүнсний зах зээлд ноёлсон франчайзууд

Шинэ бизнес эхлүүлж, түүнийгээ амжилтад хүргэхийн төлөө туулах даваа, бэрхшээл хязгааргүй бий. Харин энэ үйл явцыг товчилж, маш бага эрсдэлээр нэгэнт нэр хүндээ олсон амжилттай бизнестэй болох замыг франчайзинг нээж өгдөг. Мэдээж өөрийн бизнест тохирсон франчайзерыг олж, эрхээ авах нь нарийн төвөгтэй боловч нэгэнт дэлхий нийтээр туршин баталгаажсан, олон жилийн судалгаа, түүхтэй бизнесийн нөү-хауг эзэмшсэнээр цаг хугацаа, санхүү болоод хүчин чармайлтаа хэмнэх юм.

Аль аль талдаа ээлтэй бизнесийн загвар болох франчайзингийн түүх дундад зууны үеийн хаад ноёд татвар хураах эрхийг түшмэд, сүмийн тэргүүнүүдэд өгдөг байсан үеэс эхлэлтэй хэмээн үздэг. Харин өнөөдөр хэрэглэж буй франчайзингийн загварын эхлэлийг Singer оёдлын машины компанийг үндэслэгч энтрепренер Исаак Зингер 1880 онд минутанд 900 хатгаас хийдэг оёдлын машинаа патентжуулж, ширхэг тус бүрийг нь 120 ам.доллараар борлуулах болсонтой холбон тайлбарладаг. Тухайн үед түүнийх шиг хурдтай, хялбар ажиллагаатай оёдлын машин байгаагүй тул хөдөлмөр хөнгөлсөн тус машин Америкт гүйлгээ сайтай байсан ч хилийн чанадад хүрэх бололцоо муутай байлаа. Зингер болон түүний хамтрагчид оёдлын машин борлуулах эрхээ хувь хүмүүст худалдаж, оронд нь тэдгээр хүмүүст оёдлын машинаа тайлбарлах, зөв хэрэглэх аргыг хэрэглэгчдэд таниулах аргачлалд сургав. Энэ зохицуулалтаас хоёр тал зэрэг ашиг хүртэж байлаа. Компани илүү олон машин үйлдвэрлэн борлуулж, эрх эзэмшигчид эрэлттэй бараа худалддаг бизнестэй болсон юм.

Аливаа компанийн зах зээлийн багтаамж томорч, олон улсад дэлгэрч, эрэлт нэмэгдсэний дараа нэг эзэмшигч бүх салбарыг нээн ажиллуулах нь тухайн бизнесийг эрсдэлд оруулахаас гадна зардлыг нэмдэг. Харин үүний оронд бизнесийн технологи, нөү-хау, брэндийн нэр, барааны тэмдэгт, ашигтай загвар, бизнесийн хэлбэр, маркетингийн арга барил болон франчайзингийн эрхээ бусдад шилжүүлэн үйл ажиллагаанд хяналт тавих ба шилжүүлсэн байгууллагуудын ашигтай, ашиггүй ажилласнаас үл хамааран төлбөрөө жил бүр тогтмол авах тул ямар нэгэн санхүүгийн алдагдал хүлээхгүй. Харин хүлээн авагч тал тухайн брэндийн нэр хүндийг ашиглан өөрийн хөрөнгөөр бизнес эрхэлж байгаа учир алдаа дутагдал гаргахгүй ажиллавал түргэн ашиг олох боломжтой. Энэ бүхнийг зангидан хэлбэл франчайзинг нь зах зээлээс олуулаа ашиг олох боломжийг олгодог.

Франчайзинг эрх олгогч тал шаардлагатай зах зээлийн судалгаа, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн сургалт, материаллаг бааз, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж зэрэг компанийг аль болох түргэн ашиг олоход шаардлагатай бүх мэдээллээр хангаж, үйл ажиллагаанд нь туслалцаа үзүүлэх үүрэгтэй ба бие даасан бизнестэй харьцуулахад франчайзинг бизнес өртөг нь бага тусдаг тул зээл авах, зах зээлийн хүчтэй өрсөлдөөнийг давж үлдэх магадлал нэмэгддэг. Мөн үүнээс гадна маш нарийн судалгаа хийж, тохирсон зах зээлдээ нэвтэрсэн франчайзинг бизнес бүтэлгүй болох, дампуурах эрсдэл харьцангуй бага байдаг аж. Гэвч сүлжээ бизнесийн онцлог нь нэг л салбар дүрэм журмыг сахилгүй, хайнга хандаж алдаа гаргавал брэндийн нэр хүнд тэр чигээрээ унадаг жишээг KFC Mongolia компанийн Зайсан дахь салбарын үйлчлүүлэгчид олноороо хордсон тохиолдол харууллаа.

- **АНУ-д үйл ажиллагаа явуулж буй 759,236 франчайзинг бизнес ДНБ-ийх нь 6.1 хувийг бүрдүүлж, 8.1 сая хүнийг ажлын байраар хангаж байгаа бөгөөд энэ үзүүлэлт цаашид улам өсөх болно.**
- **АНУ-д үйл ажиллагаа явуулж буй 759,236 франчайзинг бизнес ДНБ-ийх нь 6.1 хувийг бүрдүүлж, 8.1 сая хүнийг ажлын байраар хангадаг.**
- **Монгол Улсад франчайзингийн ойлголт хожуу нэвтэрсэн ч ашигтай загварыг сонгох бизнесийн түрлэг нэмэгдсээр байна.**

Tom n Toms

Үүсгэн байгуулагч:
Байгуулагдсан он: 2001
Байгуулагдсан хот: Сөүл, БНСУ
Хэдэн оронд салбартай: 11
Салбарын тоо: 410

МОНГОЛ УЛСАД НЭЭГДСЭН ОН: 2014
МОНГОЛ ДАХЬ САЛБАРЫН ТОО: 29

СОНИРХОЛТОЙ БАРИМТ: Том бол хамгийн түгээмэл нэрсийн нэг. Залуус олноороо цуглаж, кофе уунгаа цагийг зугаатай өнгөрүүлэх газар болог хэмээн бэлгэдэж брэндээ Tom n Toms нэрийг өгчээ.

Caffe Bene

Үүсгэн байгуулагч: Ким Сун Квон
Байгуулагдсан он: 2008
Байгуулагдсан хот: Сөүл, БНСУ
Хэдэн оронд салбартай: 13
Салбарын тоо: 1000

МОНГОЛ УЛСАД НЭЭГДСЭН ОН: 2013
МОНГОЛ ДАХЬ САЛБАРЫН ТОО: 27

СОНИРХОЛТОЙ БАРИМТ: Тус кофе шопын бүх салбар харилцан адилгүй засал чимэглэлтэй байдаг ч алдарт Caffe Bene ханын цагийг заавал олж харах болно.

Burger King

Үүсгэн байгуулагч: Кит Ж.Крамер, Мэттью Бурнс
Байгуулагдсан он: 1953 /Insta-Burger King/
Байгуулагдсан хот: Жэксонвилл, Флорида, АНУ
Хэдэн оронд салбартай: 100
Салбарын тоо: 15,243
Ажилтан: 34.000

МОНГОЛ УЛСАД НЭЭГДСЭН ОН: 2015
МОНГОЛ ДАХЬ САЛБАРЫН ТОО: 6

СОНИРХОЛТОЙ БАРИМТ: Хю Лари, Женнифер Хадсон, Жорж Лукас, Жей Лено, Роберт Дауни Жр. зэрэг 12 алдартан Burger King-ийн аль ч ресторанаар насан туршдаа үнэгүй үйлчлүүлэх нууцлаг алтан карт эзэмшдэг байна.

Pizza Hut

Үүсгэн байгуулагч: Дэн ба Фрэнк Карни
Байгуулагдсан он: 1958
Байгуулагдсан хот: Вичита, Канзас - АНУ
Хэдэн оронд салбартай: 100
Салбарын тоо: 16,796
Ажилтан: 350,000

МОНГОЛ УЛСАД НЭЭГДСЭН ОН: 2014
МОНГОЛ ДАХЬ САЛБАРЫН ТОО: 13

СОНИРХОЛТОЙ БАРИМТ: Ээжээсээ зээлсэн 600 ам.доллараар бизнес эхлүүлсэн ах дүү Карнид самбарын ердөө найман үсэг хийлгэх мөнгө байсан тул ресторанаа Pizza Hut хэмээн нэрлэсэн байна.

Франчайз бүр харилцан адилгүй төлбөр, бэлтгэл зардал, үйлдвэрлэл үйлчилгээний өртөгтэй байдаг. Орлогын тодорхой хувийг суутгадаг гэрээ ч байдаг. Жишээлбэл дэлхийн хамгийн алдартай түргэн хоолны McDonald's сүлжээ рестораны салбарыг АНУ-д нээх үндсэн хөрөнгө оруулалт 1-2.2 сая ам.долларын хооронд хэлбэлздэг аж. Франчайзын гэрээг нэг компанид шилжүүлсэн бол эрх олгосон бүстээ дахин өөр компанитай тодорхой хугацаанд гэрээ хийж, нэвтрүүлэх боломжгүй болдог учир бизнес эрхлэгчдийн эрхийг давхар хамгаалж байгаа юм. Гэхдээ франчайзинг эрх худалдан авснаар ямар ч эрсдэл хүлээхгүй, шууд ашиг олно гэж ойлгох нь эндүүрэл. Франчайзингийн гэрээ аль аль талдаа хатуу байдаг бөгөөд газарзүйн байрлал, ханган нийлүүлэгч, бүтээгдэхүүн үйлчилгээ, үнэ зэргийг эрх олгогчийн зааварласны дагуу тогтоох үүрэгтэй байдаг тул энтрепренер сэтгэлгээтэй бизнес эрхлэгчид эрх чөлөөгөө хасуулсан мэт санагдаж болно. Франчайзинг эрх худалдан авагч цаашид бизнесээ үргэлжлүүлж чадахгүй болох буюу худалдахаар шийдвэл их хэмжээний торгууль төлөх үүрэг хүлээдэг нь тухайн компанийн үүрч буй хамгийн том эрсдэл юм.

Монгол Улсад франчайзингийн ойлголт хожуу нэвтэрсэн ч ашигтай загварыг сонгох бизнесийн түрлэг нэмэгдсээр байна. 2001 онд "М-Си-Эс" групп "Кока Кола" ундааг Монголд үйлдвэрлэн борлуулах онцгой эрхийг авснаас хойш саяхныг хүртэл манай улсад хоол хүнсний салбарт хуруу дарам цөөн франчайзинг бизнесийн үйл ажиллагаа явуулж байв. Нэг хэсэг унтаа байдалд ороод байсан энэ салбар 2013 онд KFC, 2014 онд Pizza Hut 2015 онд Tom n Toms болон Caffй Bene, үүнээс жилийн дараа "И-Март" хайпермаркет нээгдсэнээр эргэн сэргэсэн юм.

Залуу үеийнхэн, хүүхэд багачуудын сэтгэлийг татдаг амттанаар арвин цэстэй кофе шопууд, Улаанбаатарчуудын дуртай их дэлгүүр бүгд БНСУ-аас гаралтай. Өнгөрсөн зунаас Улаанбаатар хотын төвд хаа сайгүй үзэгдэх болсон CU сүлжээ дэлгүүр ч мөн Солонгост хамгийн олон салбартай франчайзинг юм. Сонгох боломжтой олон франчайзаас яагаад CU сүлжээг онцлох болсон талаар тус компанийн гүйцэтгэх захирал Г.Чинзоригоос лавлахад тэрбээр "Франчайзинг эрх шилжүүлэх нь хоёр компанийн хувьд томоохон мэдлэг солилцох үйл ажиллагаа юм. Маш олон сургалт зөвлөгөө, мэдээлэл, гэрээ зөвшилцөл, заримдаа гэнэтийн бэрхшээл тулгарахад тэр бүгдийг онлайнаар шийдэх боломжгүй байсан. Солонгос улс газарзүйн хувьд ойр байрлалтай, ганцхан нислэгээр очих боломжтой байдаг нь харилцааг ойр болгож байсан. Мөн монголчууд тус улсад олноор аялж, ажилладаг тул үйлчилгээ, хоолны соёлынх нь талаар харьцангуй мэдлэгтэй болсон тул эрэл хайгуул хийж, гадна болон дотоодын консалтингтай зөвшилцсөний эцэст CU-г сонгож, мөн тэдний зүгээс тавьсан олон шалгуурыг давж, тэнцэж байж франчайзинг эрхээ авсан" хэмээсэн.

CU дэлгүүрийг эзэмшигч Central Express CVS ХХК нь 2015 оноос эхлэн хотын төвийн гурван цэгт хүнсний дэлгүүр ажиллуулан, зах зээлийн судалгаа хийсний эцэст франчайзинг эрх авах шийдэлд хүрчээ. "Нэгэнт бүтээгдсэн дугуйг дахин шинээр зохион бүтээх гэж оролдоод цаг, эрч хүчээ барсны эцэст ижил үр дүнд хүрнэ гэж үзсэний үндсэн дээр бид нэгэнт зах зээл дээр 28 жил оршин тогтноод амжилт, нэр хүндээ дархалсан бизнесийн аргачлалыг худалдаж авах шийдэл гаргасан нь өнөөдөр нүдээ олсон хэрэг болжээ" гэж Г.Чинзориг мөн нэмсэн. Өнөөдрийн байдлаар 26 салбараа тус компани өөрөө удирдаж байгаа. Компани томорч, тэлэх тусам зөвхөн өөрсдөө дэлгүүрүүдээ ажиллуулахад бэрх болох нь гарцаагүй. Тиймээс ирээдүйд хувь хүмүүст франчайз эрхийг давхар эзэмшүүлж, нөү-хаугаа хуваалцах юм. Гэвч юун түрүүн брэндийн нэр хүнд, стандартыг нэгэн хэмжээнд барьж, хэрэглэгчдэд тогтсон хүлээлт, үйлчилгээний чанарыг мэдрүүлэх нь тус компанийн тэргүүн зорилго. Тус компани нийт 450 ажилтантай ба дийлэнх нь 30 доош насны залуус. Ажилтнуудаа сурган бэлтгэх, цаашид үйлчилгээг нэг стандартаар үзүүлдэг, франчайзинг эрхийг олгож эхлэхэд зөвлөх чадвартай болгоход тодорхой хугацаа шаардлагатай байгаа гэлээ. Үйлчилгээ бүрэн төгөлдөржөөгүй байхад хувь хүмүүст франчайзинг эрх олгосноор үйл ажиллагаа жигдэрч чадахгүй, хэрэглэгчдийн өмнө нэр хүндээ алдах вий гэдгээс болгоомжилж байгаа аж.

Манайд тогтсон хүнсний дэлгүүрийн хэвшлийг чангаар мэндэлж инээмсэглэн угтах ажилчид, хооллох хэсэг, үнэгүй ариун цэврийн өрөө болон нэрийн бүтээгдэхүүнээрээ өөрчилж буй CU компани дотоодын 200 орчим үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахын сацуу боловсруулалт, угсралт, савлагаа, хадгалалтын өндөр стандартыг хангасан хүнсний үйлдвэр байгуулан нэрийн хоолнуудыг үйлдвэрлэж байна. CU дэлгүүрийн аль ч салбараар үйлчлүүлсэн нэрийн хоол ижил амт чанар, стандарттай байна гэсэн үг юм. Мөн үйлчилгээний хяналт шалгалт, ариутгал цэвэрлэгээнд өндөр шаардлага тавихыг эрмэлзэж байгаа гэлээ.

CU болон ижил төст Circle K, Eco Express зэрэг дэлгүүрүүд жижиг хүнсний мухлагуудыг зах зээлээс түрэх вий гэсэн "хар" жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд байгаа юм. Гэвч бизнесийн хуулиар хямд, найдвартай, чанартай үйлчилгээ үзүүлж байж бизнес оршин тогтнох тул зах зээл дээр ч эрүүл өрсөлдөөн үүснэ. Тус компанийн зүгээс аль болох түргэн суралцаж хөл дээрээ тогтоод франчайзинг эрхээ тараасаар олуулаа хожих боломжтой хэмээн үзэж байна.

CU дэлгүүрээс хагас жилийн өмнө Монголын зах зээлд анхлан нэвтэрсэн хүнсний дэлгүүрийн франчайз сүлжээ бол Circle K. 1951 онд АНУ-ын Техас мужийн Эл Пасо хотод жижиглэн худалдааны бизнес эхлүүлж байсан тус компани өнөөдрийн байдлаар 24 оронд 12,000 орчим салбартай үйл ажиллагаагаа явуулж байна. 2019 оны босгон дээр 16 дахь дэлгүүрээ нээсэн Circle K франчайз эрх авах хүсэлтэй иргэд болон байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч эхэлсэн аж. Тус компани франчайз үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл өгөхөөс татгалзсан юм.

Монгол Улсад хамгийн амжилттай суурьшсан франчайзинг салбар нь зочид буудал. Shangri-La, Best Western Premier, Ramada, Holiday-Inn, Ibis зэрэг нэр хүндтэй зочид буудлын сүлжээ манай зах зээлд амжилттай нэвтэрч, олон улсын жишгийг тогтоосоор байна. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний франчайзинг бизнесүүд зах зээлд нэмэгдсэнээр жуулчдын тоо өсөж, дотоодыг чиглэсэн эдийн засгийн эргэлт нэмэгддэг жамтай. 2017 оны эцсийн байдлаар АНУ-д үйл ажиллагаа явуулж буй 759,236 франчайзинг бизнес ДНБ-ийх нь 6.1 хувийг бүрдүүлж, 8.1 сая хүнийг ажлын байраар хангаж байгаа бөгөөд энэ үзүүлэлт цаашид улам өсөх болно гэдгийг эдийн засагчид баталж байна.

Forbes

ZGM DAILY

President of Mongolia pays state visit to China

President is expected to take part in the high-level international meeting of BRI.

OT taxes paid to state totals USD 57.7 million

The company spent USD 2.4 billion to Mongolia for taxes, fees, and other payments.

Erdeneburen hydropower plant to inaugurate next year

It will make the five western provinces to be able to independently control the power.

Top 20 index hikes 1.01 percent, to 20,035.49 points

Market cap stands at MNT 2.33 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

The Government's debt-to-GDP ratio, which was at 78.8 percent at the end of 2016, has been cut to 58.9 percent as of the end of last year. Experts are commenting that the key driver is the Government's decision to discontinue domestic and foreign bond issuance.

ECONOMY

Bodi Daatgal JSC to become the third open-market trading company in the primary market. The company aims to attract about MNT 8.6 billion.

Khuvsgul Gold Altan Dulga JSC to disburse dividends starting from May 1st. The company decided to distribute MNT 120 to per share, a total of MNT 1.89 billion.

Top 20 index increases 1.01 percent, to 20,035.49 points. MSE A index up 2.37 percent to, 8,924.08 points. MSE B index jumps 0.62 percent, to 8,191.13 points. Market cap stands at MNT 2.33 trillion.

SOCIETY

A comprehensive disaster management training starts in Ulaanbaatar. Citizens of the capital city involved in post-earthquake relief exercises on April 25, 07:00 am to 09:30 am.

Judoka Tsogtbaatar Tsend-Ochir defeats world champion on Chand-Rim at the Asian Pacific champions held in Fujairah in the UAE.

Mongolian Institute for Brain Science with equipment of MNT 2.4 billion commences.

President pays his first state visit of this year to China

During his tenure, President Battulga Khaltmaa participated in severalhigh-level meetings.



President to attend the BRI summit on April 26-28

Aminaa.U
ZGM

The President of Mongolia Battulga Khaltmaa is paying his first state visit to China of this year at the invitation of his Chinese counterpart Xi Jinping. He is expected to visit the State Assembly on today and will take part in the high-level international meeting of Belt and Road Initiative (BRI) on April 26-28, reported the Ministry of Foreign Affairs.

The President is being accompanied by the Minister of Foreign Affairs of Mongolia Tsogtbaatar Damdin, Ambassador Extraordinary and Plenipotentiary of Mongolia to China, Deputy Speaker of the Parliament, Speaker of the Mongolian-Chinese Parliamentary Group in the Parliament, Minister of Food, Agriculture and Light Industry, Minister for Road and Transportation, Head of the Office of the President of Mongolia Enkhbold Zandaakhuu, Secretary of the National Security Council, representatives and working groups, and press releases representatives.

During his tenure, President Battulga Khaltmaa participated in several high-level meetings, twice in the Eastern Economic Forum in Vladivostok, Shanghai Cooperation Summit last year, the Asia-Europe Summit in Belgium, and the World Investment Summit in Switzerland.

As a matter of fact, President Battulga addressed the issue of transit of natural gas pipeline connecting Russia and China at the East Asian Economic Forum in Vladivostok, Russia.

"The development of the relationship with the Shanghai Cooperation Organization will be a real challenge to the regional infrastructure," he addressed when he previously participated in the Shanghai Cooperation Summit. [ZGM]

COMMODITY MARKET



MINING

OT taxes paid to state totals USD 57.7 million in Q1

Oyu Tolgoi (OT) LLC announced its 2019 first quarter performance report. OT spent USD 2.4 billion to Mongolia for taxes, fees, and other payments during the first quarter of 2010-2019. For instance, in the first quarter of 2019, USD 57.7 million was paid to the budget and USD 28 million was paid to VAT.

The company also cooperated with 531 suppliers. In terms of mining, gold production increased by 187.6 percent compared to the first quarter of 2018. The ore concentration in the IV stage was up by 135.2 percent. However, gold production is expected to decline significantly over the remaining period of 2019, particularly in the second half, depending on the soft, low-grade content of the ore and ore stockpiles. The average copper content is also estimated to drop in the rest of the year, according to the OT. [ZGM]

ENERGY

Erdeneburen hydropower plant to be commissioned next year

The feasibility study of Erdeneburen hydroelectricity is underway and is expected to complete in August. Inter-ministerial agreements and negotiations have started under the milestone to start the construction in the fourth quarter of next year.

"The previous government issued the plant construction to continue under a concession agreement and the National Development Agency have announced an open bid. However, companies could not handle the project as the selling and purchasing price of the investment was uncertain and the feasibility was made a decade ago. Prime Minister Khurelsukh Ukhnaa issued a decree to draw soft loan from China in 2018 because the project became unable to proceed with the concession agreement. As a result, we are now in the process of solving Chinese soft loans. An official letter from China has required to renew the feasibility in order to grant the loan from the EXIM Bank," said spokesman of the Erdeneburen hydroelectricity project to a local media outlet this week.

Once the feasibility study is revised, the law should provide a detailed environmental assessment. According to Chinese experts, the revised feasibility could increase the plant's power capacity from 64 MWT to 90-100 MWT with a technological upgrade. It will make the five western provinces to be able to provide their power independently and supply the excess electricity to the central region at peak hours.

The reason behind the inability to advance the project in 2008 was because the soil went 40-50m below the ground level, and the production costs were too high at the time. Also, it is not possible to use the Orkhon and Eg rivers because of the complicated border agreement with the Russian Federation.

The project is being implemented under the agreement between the two governments of Mongolia and China. It is expected to create approximately 60-80 workplaces. [ZGM]

MMC's Ukhaa Khudag deposit mine produces 9.5 Mt of ROM

Mongolian Mining Corporation (MMC)'s Ukhaa Khudag deposit (UHG) mine has produced 9.5 Mt of run-of-mine (ROM) coal in 2018, which represents a historical high in annual output since its commissioning in April 2009. To access coal, a total of 44.3 million bank cubic meters (bcm) of prime overburden was removed, resulting in an actual stripping ratio of 4.67 bcm per ROM ton for the period.

The Baruun Naran deposit (BN) mine has produced 1.4 Mt of ROM coal in 2018, which also represents a historical high in annual output since its commissioning in February 2012. To access coal, a total of 9.7 million bcm of prime overburden was removed, resulting in an actual stripping ratio of 6.98 bcm per ROM ton for the period. Thus, the Group's total ROM coal production reached 10.9 Mt in 2018, representing a 30.3 percent increase from 8.3 Mt reported for 2017. The Group's combined annual mine production from UHG and BN mines for the last three years.

The Group has processed a total of 10.0 Mt of ROM coal in 2018, which represents a 25 percent increase from 8.0 Mt processed in 2017. During this period, the Group processed 8.9 Mt and 1.1 Mt ROM coal sourced from UHG and BN mines, respectively.

MMC is a high-quality coking coal producer and exporter in Mongolia. The Company owns and operates Ukhaa Khudag and Baruun Naran coal mines, both located in South Gobi, Mongolia. The annual general meeting of Mongolian Mining Corporation will be held in Hong Kong on May 30, 2019. [ZGM]



Өдрийн хэмнэл

ЗУРХАЙ



Билгийн тооллын 21
Хаврын адаг шар луу сарын гурван хөх мэнгэтэй хар луу өдөр
Үс засуулбал: Өвчин ирнэ
Наран ургах, шингэх: 05.46-19.55
Барилдлага: Үл зохилдох
Шүтэн барилдлага: Төрөхүй
Суудал: Гал

Аргын тооллын дөрөвдүгээр сарын 25. Бархасвадь гараг. Билгийн тооллын 21. Суулга одтой, хар луу өдөр.
Өдрийн наран 05.46 цагт мандан, 19.55 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лус тахих, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой.

Ж.Пуччини "Тоска" дуурь
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.04.28-ны 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

"Chamber Music Concert" концерт
Хаана: Улсын Филармони
Хэзээ: 2019.04.26, 27-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮25 мянга

Э.Чойдог "Шарилжин дундах цэцэг", Н.Римский-Корсаков "Щехерезада" бүжгэн жүжиг
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.04.27-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

Цуурхал хэрхэн түгдэг вэ

"Этик" продакшны хоёр дахь бүтээл "Цуурхал" уран сайхны кино маргаашнаас кино театруудын дэлгэцнээ гарч эхэлнэ. Нийгмийн сүлжээн дэх зохисгүй доромжлол, дам яриа хүний амьдралд хэрхэн нөлөөлж болохыг энэхүү киногоор харуулахыг зорьжээ.

Гол дүрийн бүсгүйн ээдрээт амьдрал, хувь тавилан, хайр харуусал энэ үед хэрхэн өөрчлөгдөх бол. Хэргийн нарийн зангилааг тайлахаар хичээж буй гурван мөрдөгчийн хөгжилтэй арга барил киног хэрхэн сонирхолтой болгохыг тус уран бүтээлээс хүлээн авч үзээрэй.

Детектив, инээдмийн төрлийн "Цуурхал" уран сайхны киноны продессероор Г.Золжаргал, найруулагчаар Г.Даваазул ажиллаж, гол дүрүүдэд "Этик" продакшны жүжигчин А.Энхжин, Ч.Баярмаа, Е.Даваасүрэн нар тоглосон байна. [ЗГМ]

"Carmencita" концерт
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.01-ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 50 мянга

"Мөнхийн хүсэл" сонгодог концерт
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.02-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 20 мянга

Б.Шарав "Чингис хаан" дуурь
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.05.04-ний 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ЗГМ: СҮДОКУ

		1		6	9			3
3	8			5			9	2
	9	5		8	2		4	
		6			1			
		3	6			8		
			8	9		7	5	
					4		6	1
						2	3	
					8			

(Өмнөх дугаарын хариу)

3	4	8	2	6	7	9	1	5
5	9	2	1	4	3	7	8	6
7	1	6	8	5	9	4	3	2
6	7	1	4	8	2	3	5	9
2	8	3	7	9	5	6	4	1
9	5	4	6	3	1	2	7	8
4	6	7	5	2	8	1	9	3
8	2	9	3	1	4	5	6	7
1	3	5	9	7	6	8	2	4

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ
3. Ургамлын тэжээлийн эрхтэн
4. Буурал тив
5. Хиларитай хамт дэлхийн дээвэр Эверестэд гарсан анхны хүн Дэнзэн...
6. "Боохой" хочит хүчит арслан
7. Муруй, тахир
8. Гэрлэн бүрхүүлээ засах арга, оношилгоо
13. Дээд үнэлгээ
15. Цагаан мод шидэж олох тоглоом ...хаях
17. Хөгжмийн нот
18. Ээ, түнжин

ХӨНДЛӨНГӨӨР:
2. VIII Богдыг гамингийн шоронгоос суллан суудалд нь залсан цагаан Оросын цэргийн жанжин
6. "Дайсны цэргүүдээ сонсоцгоо" киноны дууг дуулсан жүжигчин (МУГЖ)
9. МУГЖ, дуучин бүсгүй
10. Мал амьтны толгойн яснаас ургаж гарсан зүйл
11. Хамар дээрээ эвэртэй лагс биетэй амьтан
12. Цайны газар
13. АНУ-ын телевизийн од, саятан бүсгүй
14. Цагаан идээ
16. Цогт хун тайжийн ач хүү Сутайн хэргэм цолоор нэрлэгдсэн хошуу (Сайн ноён хан, ... бэйл)
19. Нэгэн зүйл тогорууны нэр
20. Арьс шир идээлдэг шүлтлэг бодис

Өмнөх дугаарын хариу / 04.24

Р А Д Н А А Б А З А Р
О А Ү Э
Э В Э Р Б Ү Р Э Э
Н Ү О
О Г У Р У М А
Э Э Е
Х Ү Р Э Н М О Р Ь
Е Б А Т
М А Н Д А Х Н А Р А Н

ЧОН КВАН ЖАН брэнд
Солонгос улаан хүн орхоодой

"Чон Кван Жан" улаан хүн орхоодойн онцлог:
Хүн орхоодойг голдуу 4-5 жил ургасныг нь цагаан гэх ба 6 жил ургасан хүн орхоодойг улаан хүн орхоодой гэнэ. Улаан хүн орхоодойд SAPONIN /сапонин/ гэдэг элемент маш ихээр агуулагддаг. Сапонин нь хүний биеийн эд эсийн үүргийг идэвхжүүлэн сэргээж, бактери устгаж, өвчин эсэргүүцэх чадварыг дээшлүүлэн дархлааг сайжруулна. Чон Кван Жан брэндийн хүн орхоодойн бүтээгдэхүүнийг зөвхөн 6 жил тарьж ургуулсан хүн орхоодойгоор хийдгээрээ онцлогтой.

Чанарын гэрчилгээ

Korean ginseng корпораци дараах баталгаа гаргаж байгаа болно. Чон Кван Жан брэндийн улаан хүн орхоодойн бэлдмэл нь Солонгосын эрүүл мэндийн шилдэг 10 бүтээгдэхүүний тэргүүнд тооцогддог ба хамгийн шилдэг бүтээгдэхүүндээ энэхүү чанарын гэрчилгээг олгодог.

OLKHAN
Эрэгтэйчүүдийн бэлдмэл

Эрэгтэй хүний амьдралын хэвшлийг харгалзан уламжлалт түүхий эдээр хийсэн стрессээс үүдэлтэй ядаргааг тайлах болон тамир тэнхээнд зориулсан эрүүл мэндийн цогц бүтээгдэхүүн юм.

Үр дүн
- Эрчүүдийн бэлгийн чадавхыг сайжруулна.
- Эцэж цуцашгүй эрч хүчийг бэлэглэнэ.
- Бие организмд хүч чадал оруулж сэргээнэ.
- Архи, тамхи, стрессээс үүссэн ядаргааг тайлна.
- Өөртөө итгэлтэй болж амьдралын идэвх сайжирна.

WOMEN BALANCE BON
Эмэгтэйчүүдийн бэлдмэл

Эмэгтэй хүн нас ахих тусам эмэгтэй гармон багасаж өвчин үүсэх шалтгаан болдог. Эмэгтэйн гармоныг идэвхижүүлж, нөхөн төлжүүлдэг ба цэвэршилтийн үеийн шинж тэмдгийг намдаах онцгой үйлчилгээтэй.

Үр дүн
- Эмэгтэйчүүдийн цэвэршилтийн үеийн шинж тэмдгийг намдаана
- Сарын тэмдгийг тогтворжуулж өвдөлтийг намдаана
- Эрүүл, эрч хүчтэй гэр бүлийн харьцааг төрүүлнэ
- 30 аас дээш насны эмэгтэйчүүдэд дутагддаг кальцийг нөхөж яс бэхжүүлнэ.
- Залуу насны эрч хүч хадгалж баланс тэнцвэржүүлнэ.

EXTRACT LIMITED
Хүн орхоодойн өтгөрүүлсэн ханд

Дээд зэргийн хандалсан бүтээгдэхүүний хувьд хүний биед амархан шингэдэг тул үр дүн нь түргэн илэрдэг.Тамир тэнхээ эрс сульдсан үед хэрэглэвэл бие болоод сэтгэлийн ядаргааг тайлж эрч хүчийг сэргээж өгнө.

Үр дүн
- Ядаргаа тайлна.
- Дархлаа сайжирна.
- Ой тогтоолт нэмэгдэнэ.
- Цусны эргэлт идэвхжинэ.
- Тамир тэнхээ сайжирна.

Утас: 9962-2078, 8805-5943

Бүс ба замын төсөлд авлигаас зайлсхийж чадах уу

Бүс ба замын аварга санаачилгын хүрээнд хэрэгжүүлж буй зарим төсөл авлигад өртөж, зардлаа нөхөх чадваргүй болжээ. > 10

Газрын тосны үнийн өсөлтөөс ОХУ хамгийн их хожлоо

Шинэ тутам зах зээлүүд он гарсаар Холбооны нөөц, Дональд Трамп, Шин Жиньпин нараас ашиг хүртсэн. > 10

ДНХ-ийн сорилын бизнес тэлснээр Ancestry IPO хийхээ зарлав

ДНХ-ийн сорилыг хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, эрүүл мэндийн технологид мөнгө оруулах сонирхол өссөн. > 10

Засгийн газрын кабинетын тэргүүн Ёшихидэ Суга Японы шинэ тооллын нэрийг танилцуулав.

Өөрчлөлтийн 30 жилийн дараах шинэ эрин

Бретт Миллер

Японд 30 жилийн өмнө шинэ Эзэн хааны "Хэйсэй" тооллыг зарлах үед дэлхийн түүхэн дэх хувьцааны үнийн хамгийн аварга өсөлтийн нэг тохиолдож байлаа. Газар хөдлөлт, цунами, цөмийн ослын гурвалсан цохилт, цахим үйлдвэрлэгчдийн уналт, автомашин үйлдвэрлэгчдийн сэргэлт, эдийн засаг дахь эмэгтэйчүүд, гадаадынхны үүргийг ихэсгэх нийгмийн өөрчлөлт Хэйсэйгийн эринд "тамга" болон үлдэх нь. Эдийн засгийг эргүүлэн сэргээх зорилготой эдийн засгийн радикал туршилтын ид үед Эзэн хаан ширээнээсээ буухаар бэлтгэж байна. Хэйсэйгийн эринд тохиолдож өнгөрсөн эдийн засгийн өөрчлөлтийг товч дүгнэж үзье.

АНУ-ын Dow Jones үйлдвэрлэлийн дундаж индекс 1950-иад оны түвшинд сэргээд байхад Nikkei-225 дундаж индекс 30 жилийн турш сул хэвээр байна. Энэ нь Японыг дэлхийн эдийн засагт гуравдугаар байранд ухраасан бэрхшээлийн цар хүрээг харуулна. Японы дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ (ДНБ) арваад жилийн өмнөөс БНХАУ-ын ард бичигдэх болж, зөрүү нь улам өссөөр байна.

Энэ хугацаанд Sony Corp зэрэг Японы зарим агуу компанийн нэрс бүдгэрсэн. Аналог технологийн эринд Walkman кассет тоглуулагч зэрэг бүтээгдэхүүнээрээ зах зээлийг шуурууллдаг байсан, өргөн хэрэглээний цахим бараа үйлдвэрлэгч, Токиод төвтэй компани дижитал эриний Apple Inc, Samsung Electronics Co зэрэг шинэ аваргуудад түрэгдэв. Sharp Corp, Panasonic Corp зэрэг алдартай компанийн үнэлгээ ч уналаа.

Японы эдийн засаг арваад жилийн өмнөөс Хятадад гүйцэгдэж, зааг ялгаа улам ихэссэн
(их наяд ам.доллараар)



World bank©

Toyota, Volkswagen-ы орлого GM-ынхоос хол тасарлаа
(тэрбум ам.доллар)



World bank©

Даян дэлхийд хямрал нүүрлэсэн цаг үед хөрөнгө оруулагч нар бодлогын хэт бага хүүтэй иен сонирхох нь эрс өсөв. Хэйсэйгийн үед Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүний 230 хувьд хүрсэн ч Японы экспорт их хэвээр, урсгал данс ашигтай гарсаар буй. Япон нь дэлхийн гол зээлдүүлэгчдийн эгнээнд багтсаар байгаа нь Засгийн газрын өр зээлд түгших түгшүүрийг багасгаж, иенд итгэх итгэлийг бэхжүүлэх гол нөхцөл болдог. Тус улс АНУ-ын Сангийн яамны нийт нэг их наяд гаруй ам.доллараар хэмжигдэх үнэт цаас хадгалж байгаа нь БНХАУ-ын мэдэлд байгаагаас үл ялиг бага байгаа юм.

Японы автомашины үйлдвэрлэл цар хүрээгээ тэлсээр Европын аваргуудтай халз үзэлцэж, АНУ-ын өрсөлдөгчдийг арагш шахсан. Toyota дэлхийн ихэнх манлай брэндээс толгой дээгүүр, гибрид автомашины үйлдвэрлэлээр тэргүүлэгч, цахилгаан машины ирээдүйг тодорхойлогчийн нэг болж хувирлаа.

Японд явц муутай өрнөж ирсэн хүйсийн эрх тэгш бус байдлыг багасгах хүчин чармайлт ажиллах хүчний хомсдолтой уялдан сүүлийн жилүүдэд эрчээ авч байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт ихэссээр байгаа ч ихэвчлэн цагийн ажил, түр гэрээт ажлын байраар хязгаарлагддаг. Сонирхолтой нэг зүйл бол Японы ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн оролцоо АНУ-ынхаас давсан явдал юм. Бодлого тодорхойлогчид тавдугаар сарын 1-нээс эхлэх Рэйва эринд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт шинэ шатанд дэвшинэ хэмээн найдаж байгаа.

Японы хүн ам сүүлийн найман жилийн турш цөөрч, гурван хүн тутмын нэг нь 60-аас дээш насныхан болж хувирлаа. Үүссэн нөхцөлөөс шалтгаалж бизнесийн салбар үйлчлүүлэгчээ төдийгүй ажиллах хүчээ алдаж буйтай уялдан дотоодод хөрөнгө оруулах сонирхол буурах төлөвтэй. Тогтолцоог дэмжиж тулах татвар төлөгчдийн бааз суурь суларснаас нийгмийн халамжийн зардал Засгийн газарт хүнд ачаа болж хувирлаа. Инфляцыг өсгөж, эдийн засгаа өөд татахын тулд мөнгөний бодлого тодорхойлогчид бонд худалдаж авах ажиллагааг эрс ихэсгэж, зээлийн хүүг үнэмлэхүй бууруулах бодлого хэрэгжүүлж байна. Японы төв банк бодлогын хүүгээ 1999 онд тэглэснээс 20 жилийн дараа богино хугацааны зээлийн хүүг хасах 0.1 хувьтай тогтоосон юм. Мөнгө зээлийн түлхэц өгөх бодлого Японы бага хувьтай хүү, сул өсөлтийн бэрхшээлийг залруулж чадахгүй байгаа юм. Хэрэг дээрээ хөгжингүй ертөнцийн бусад хэсэг ч үнэ өсгөх тэмцэлд ялагдал хүлээсэн. АНУ-ын Холбооны Нөөцийн Систем 2019 оныг стратегиа эргэн харах жил болгосон бол Европын үлбэгэр эдийн засгийг "японжуулах" замаар амь оруулах тухай ярьдаг хүмүүс ч гарч ирлээ.

АНУ-ын нефть БНХАУ руу дахин цутгаж эхэллээ

АНУ-аас импортолдог Хятадын газрын тосны хэмжээ
(сая тонноор)



Хятадын Гаалийн ерөнхий газар ©

Серена Чеон

Ази тивийн газрын тосны гол худалдан авагч дэлхийн хамгийн хурдацтай томорч буй нийлүүлэгчийн тосноос татгалзаж чадахгүй бололтой. АНУ-ын газрын тос ачсан супертанкер Азийн хамгийн завгүй боомтуудын нэгэнд ачаагаа суллахаар Хятадын дорнод эргийг чиглэн хөвж явна. Вашингтон, Бээжингийн хоорондох худалдааны зөрчил зөөлөрч эхэлж буйтай уялдан АНУ-аас тээврийн бусад усан хөлгүүд ч уг танкертай удахгүй нэгдэнэ.

Хоёр их гүрэн бие биедээ тавьсан тарифын улмаас Хятадын нэрэх үйлдвэрүүд АНУ-аас экспортолдог газрын тосноос саяхан болтол татгалзаж байв. Гэвч дэлхийн тэргүүлэх хоёр эдийн засаг худалдааны зөрчлөө шийдвэрлэх хугацаа ойртсонтой уялдан худалдан авах сонирхол нь эргээд сэргэлээ. Геополитикийн донсолгоон Иран, Венесуэлийн нийлүүлэлтийг тасалдуулсантай уялдан АНУ-аас газрын тос худалдан авах нь засгийн газрын зохицуулалтыг зөрчсөн хэрэг болохгүй хэмээн худалдан авагчид тооцоолж буйг Азийн нэрэх үйлдвэрүүдийн төлөөлөгч, арилжаач нар тайлбарлав.

Төрийн өмчит газрын тосны Sinopec аварга үйлдвэрлэгчийн харьяа Unipec компани Мексикийн булангаас АНУ-ын газрын тосыг тавдугаар сарын 20 гэхэд Хятад руу тээвэрлүүлэхийн тулд Coswisdom Lake танкерийг хөлсөлжээ. Нийт хоёр сая баррель газрын тос тээвэрлэх даацтай уг танкер нь Occidental Petroleum Corp, Mercuria Energy Group, Sinochem Group, Equinor ASA зэрэг компаниас мөн адил тээвэр хийлгэхээр гэрээлсэн олон хөлгийн ердөө ганц нь юм.

Мөн газрын тос тээвэрлэх Maran Artemis танкер Чиндаогийн боомтод 20 метрийн суулттай зогсож байгаа нь бүрэн ачаатайг илтгэж байна. Bloomberg-ийн статистикаас үзвэл уг танкер хоёрдугаар сарын эцсээр Техасын Галвестоны эрэг дэх Southtex шилжүүлэн ачих хэсгээс АНУ-ын газрын тос ачиж хөдөлсөн аж.

Хятадын нэрэх үйлдвэрүүд 2018 онд АНУ-ын эх газрын гүн дэх занарын тосноос Мексикийн булангийн цооногийн тос хүртэлх бүх бараарыг идэвхтэй худалдан авсны дүнд импортын хэмжээ 2018 оны нэгдүгээр сард хоёр сая гаруй тонн болж үнэмлэхүй амжилт тогтоосон юм. Дараа нь хоёр улсын удирдагчдын яриа хэлэлцээтэй уялдан импорт нь аравдугаар сард үндсэндээ зогсжээ.

SpaceX радио холбооны зөвшөөрөл авахаар хөөцөлдөж байна

Тодд Шилдс

Илон Маскийн Space Exploration Technologies Corp ирэх сард хөөргөх сансрын хөлөгтэйгөө радио холбоогоор харилцах зөвшөөрлийг зохицуулах байгууллагаас хүслээ. Уг хүсэлт нь дэлхий орчмын нам тойрог замд мянга мянган жижиг хиймэл дагуул зорчуулах өрсөлдөөнд бас нэг алхам болов. SpaceX-ийн хиймэл дагуулуудын эхний хэсгийг тавдугаар сарын эхээр хөөргөхөөр төлөвлөж байна.

Nintendo-гийн хувьцааны үнэ Хятадын ачаар өслөө

Южи Накамура

Видео тоглоомын борлуулалт сайжирч, БНХАУ-ын зах зээлд нэвтрэх боломж нээгдсэнтэй уялдан Nintendo-гийн хувьцааны үнэ өслөө. БНХАУ-ын зохицуулах байгууллага Switch консолыг дотоодод борлуулах зөвшөөрлийг баасан гарагт олгосны дараа Nintendo-гийн хувьцааны үнэ шууд 15 хувиар өссөн юм. Японы видео тоглоом үйлдвэрлэгчийн хувьцааны үнэ он гарсаар 27 хувиар өссөн нь 2015 оноос хойших үнэмлэхүй үзүүлэлт болов.

Венесуэл сүүлийн таван жилд анх удаа нефть импортлов

Люсиа Кассай

Венесуэлийн газрын тосны үйлдвэрлэл шалдаа буусан тул сүүлийн таван жилд анх удаа гаднаас нефть импортоор авч эхэллээ. Гуравдугаар сард тус улсын олборлолт өдөрт нэг сая баррель хүрэхгүй болсон нь сүүлийн 15 жилийн үнэмлэхүй уналт болсон юм. Цахилгаан хангамж тасарсантай уялдан газрын тосны орд, дамжуулах хоолой, ачиж буулгах боомт зэрэг дэд бүтцийн ажиллагаа тасалдсан нь төрийн өмчийн Petroleos de Venezuela SA компани Нигери улсаас газрын тос импортлохоос аргагүй нөхцөл үүсгэжээ.

Вудстокийг дэмжигчид брэндээ экспорлох эрмэлзэлтэй

Росс Кеннет Уркен

Орлого ашгийн бус, дурлал хайрын зун байжээ. Майкл Лэнг түншүүдтэйгээ байгуулсан Woodstock Ventures компани 1969 онд Вудстокийн хөгжмийн их наадмыг зохион байгуулаад 1.3 сая ам.долларын алдагдал хүлээсэн юм. Их наадам зохиосон гол шалтгаанаа "мөнгө байгаагүйгээс" хэмээн эдүгээ 74 настай хөгшин саяхан Вудстокт өгсөн ярилцлагынхаа үеэр тайлбарлав. "Болж байгаа үйл явдалдаа л хөөрч гүйцсэн юм даг. Учир нь бүгдийн хүсээд байсан юм л болсон хэрэг. Ердөө л стероид" хэмээн тэрбээр дурсаж байна. Одоо бол Лэнг хашир туршлагатай бизнесмен.

Вудстокийн 50 жилийн ойд зориулан Нью-Йорк муж улсын Уоткинс Глэннд ирэх наймдугаар сард гурав хоногийн их наадам зохиох гэж буй Майкл Лэнг хөгжмийн чухал арга хэмжээгээ Японы зар сурталчилгааны аварга Dentsu-гийн салбар-Dentsu Aegis Network-ийн санхүүжилт, маркетингийн дэмжлэгтэйгээр дэлхийд түгээн дэлгэрүүлэхээр төлөвлөж байна. Жил бүр өөр улсад болох шинэ Вудстокийг зохион байгуулах талаар хэдийн Япон, Бразил, Испанитай ярилцсанаа Лэнг тайлбарласан юм.

"Миний төлөвлөгөө бол Вудстокийн жил тутмын наадам зохиохдоо биш. Тэртээ тэргүй хөгжмийн наадам зөндөө" хэмээн Лэнг өгүүлж байна. Орчин үеийн ихэнх их наадам дуу хөгжмийг үнэлж, нийгмийн чухал асуудлыг ухамсарлуулахын оронд, сошиал пост ахиу оруулахад чиглэсэн "амттан хэвлэдэг машин"-тай төстэй болсон хэмээн промотер шүүмжиллээ.

Хөгжмийн их наадам зохион байгуулах нь том бизнес. Калифорнийн Коачелла (Coachella) их наадам 2017 онд анх удаа зохиогдохдоо 100 сая ам.долларын орлого олсныг Billboard Boxscore тооцоолжээ. Rolling Stones, Боб Дилан, Нил Янг нар оролцсон 2016 оны Desert Trip (Oldchella) их наадам хоёрхон хоногт 160 сая ам.доллар олсон юм. Гэхдээ Коачелла, SXSW, Burning Man, Боннару зэрэг мөнгө олдог нэртэй юм наадмуудаас ялгаатай нь Вудстокийн хиппинүүд зарахын оронд худалдаж авах гээд байгаа хэрэг.

Вудстокийн бизнес нь Вудстокийн санааг түгээхэд чиглэх ёстой хэмээн Лэнг үздэг. Энх тайван, хайр дурлалыг хайрцаглаад зарах хэрэгтэй. "Юм боддог сэтгэдэг хүмүүст чиглэнэ. Оролцоо хэрэгтэй. Жишээ нь, дэлхийн дулаарал яах аргагүй аюул болчихлоо" хэмээв

Шинэ Вудсток нь галт зэвсэгт хяналт тавих March for Our Lives, сонгогчдыг бүртгэх ашгийн бус Head Count, байгаль орчин хамгаалах Conservation International зэрэг байгууллагатай хүмүүсийг холбож өгөх хэсэгтэй байх юм.

Майкл Лэнгэд өрсөлдөгч ч бий. Алдарт их наадам анх болсон газарт боссон Бетель Вудсын урлагийн төв (Bethel Woods Center for the Arts) Ринго Старр, Сантана зэрэг оддын оролцоотойгоор мөн л Вудстокийн жил тутмын арга хэмжээ зохион байгуулдаг. Бетель Вудсын шоуг санаатайгаар өрсөлдөгч арга хэмжээ болгон сурталчилдаг, зохион байгуулагч Live Nation компанийг тэрбээр ширүүн шүүмжилж байлаа. Уг шоуг зогсоох шаардлага тавьсан захидлыг Live Nation-д илгээснээ тэрбээр тайлбарласан юм.

Эдийн засаг

Хятадын тал тус санаачилгад хөгжингүй орнуудыг татан оролцуулснаар ядуу улсад төсөл хийх эрсдэлийг бууруулах, төслүүдийг улс төрийн нөлөөгөө өргөжүүлэхэд ашиглаж байна гэсэн шүүмжлэлээс зайлсхийх зорилго тавьж буй бололтой.

ВВМ©

"Бүс ба Зам" төсөл авлигаас зайлсхийж чадах уу

Bloomberg News

Хятадын Ерөнхийлөгч Ши Жиньпиний эхлүүлсэн "Бүс ба Зам" аварга санаачилгын хүрээнд хэрэгжүүлж буй зарим төсөл авлигад өртөж, зардлаа нөхөх чадваргүй болж байгаа тул сурталчилгааг нь намжааж, хяналтыг сайжруулах алхам хийж байна. Бээжин уг төслийн хяналтыг чангатгахын сацуу олон улсын үйлдвэр оролцох журмыг тодорхой болгох, төслийн брэнд нэрийг ашиглахыг хязгаарлах, гадаадад аудитын ба авлигын эсрэг механизм бий болгох гэх мэт өргөн хүрээтэй арга хэмжээ авч байгааг албаныхан мэдээлжээ.

Түүнчлэн Хятадын тал тус санаачилгад хөгжингүй орнуудыг татан оролцуулснаар ядуу улсад төсөл хийх эрсдэлийг бууруулах, төслүүдийг улс төрийн нөлөөгөө өргөжүүлэхэд ашиглаж байна гэдэг шүүмжлэлээс зайлсхийх зорилго тавьж буй бололтой. Гэвч Үндэсний хөгжил, шинэчлэлийн комисс болон бусад байгууллага "Бүс ба Зам" төслийн талаарх асуулгад хариу өгсөнгүй.

Энэ долоо хоногт дэлхийн удирдагчид "Бүс ба Зам" форумд оролцохоор Бээжинд цуглахад Хятадын тал худалдааны дайн болон Ази, Европ дахь улс төр, эдийн засгийн байр сууриа хамгаалах бодолтой байна. Эрх баригчид "Made in China 2025" арга хэмжээ, гадаадад амьдарч буй хятадуудыг буцаан татах "Мянган авьяастан" гэх мэт хөтөлбөрийн талаарх албан мэдээлэл, мэдэгдлүүдийг хянан засварлах арга хэмжээ авав.

Денвер дэх Олон улсын сургуулийн Хятад, АНУ-ын харилцааны төвийн захирал Сюшен Жао "Худалдааны дайн эхэлснээс хойш Хятад улс гадаад, дотоодын эсэргүүцэлтэй тулгарч, Нанжины их сургуулийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн профессор Жу Фен "Сүүлийн үед төслийг хөгжингүй орнууд төдийгүй хөгжиж буй үндэстнүүд шүүмжлэх болсонд Хятадын Засгийн газар сэтгэл дундуур байгаа. Олон улсын шахалт Хятадыг урагш алхахад хүргэж байна" хэмээн өгүүлэв.

зарим оронд ухралт гарсан тул намаас олон нийтийн харилцаа, ялангуяа олон улсын имижийг эргэн харж байна. Гэвч үг яриагаа өөрчлөөд ялгаа гарахгүй байх. Хятадын олон улсын имиж үндсээрээ өөрчлөгдөж, аядуу зөөлөн Хятадаас шургуу итгэлтэй Хятад руу шилжсэн" хэмээв.

Хятад улс санаачилгаа Европ руу тэлэхээр ажиллаж буй учир "Бүс ба Зам" төслийн цаашдын хөгжилд хатуу стандарт бий болгох зорилт нэмэгджээ. Итали улс Их долоогийн орнуудаас түрүүлэн энэ онд "Бүс ба Зам"-д нэгдэхээ мэдэгдсэн нь Хятадын хувьд томоохон ялалт боллоо. Гэхдээ Европын бусад оронтой хэлэлцээ хийхэд зохицуулалт ба стандартын бэрхшээлүүд гарч ирнэ гэж учрыг мэдэх эх сурвалж ярилаа. Тухайлбал, санхүүжилтийг ОУВС болон Европын Холбооны шаардлагад нийцүүлэх асуудал яригдана гэжээ.

Ноён Жу Фен "Хөгжингүй орнуудтай хамтын ажиллагаагаа тэлнэ гэдэг нь өрнөдийн стандартад нийцүүлнэ гэсэн үг. Хятадын эрх баригчид ил тод байдал, зохицуулалтад нийцэх зорилтод гуравдагч хамтын ажиллагааг чухалчилж эхэлсэн" хэмээн тайлбарлав. Гуравдагч зах зээлийн түншлэл гэдэг нь аль нэг улсад дэд бүтэц барихад хөгжингүй орны туслалцааг авна гэсэн үг юм. Ийм замаар улстөржилтөөс зайлсхийж, форумын үеэр Британи, Швейцар, Австри улстай хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурахаар бэлтгэж байна. Өмнө нь Франц, Испани, Австралитай гэрээ байгуулсан билээ.

Хятадын онилсон нэг зорилго бол авлига. Ноён Ши дотооддоо авлигын эсрэг тэмцлийг зургаан жил явуулж, сая гаруй түшмэлд шийтгэл ногдуулсан. Одоо албаныхан "Бүс ба Зам"-тай холбоотой авлигыг дарах механизм бий болгохоор оролдож байна. Төсөлд хамрагдсан олон улс санхүүгийн ил тод байдал муу, зээлжилтийн доогуур зэрэглэлтэй байгаа. Үүнээс улбаалан авлигын өндөр түвшинтэй орнуудын улстөрчид ба түшмэлүүдэд төслийн явцад төлбөр өгөх явдал нэлээд гарсан.

Улсын мэдээллийн байгууллагууд форумыг бүрэн хэмжээгээр сурвалжлахаа больж байгааг зарим дипломат ярьсан юм. Өмнө нь төслийг хэт дуулиантай ярьж, сурталчилсан нь сөрөг үр дүнтэй болохыг эрх баригчид хүлээн зөвшөөрч буй бололтой. Бээжин дэх Ренмин их сургуулийн профессор Ши Инхон "Хятад улс дэлхий ертөнцтэй харилцах туршлага хуримтлуулж байна. Худалдааны дайн ба тус төслөөс авсан сургамж гадаадын бодлогыг богино хугацаанд ухаалаг болгох нь дамжиггүй" хэмээн өгүүлжээ.

Газрын тосны үнийн өсөлтөөс ОХУ хамгийн их хожлоо

Бен Бернштейн

Шинэ зах зээлүүд он гарсаар Холбооны нөөц, Дональд Трамп, Шин Жиньпин нараас ашиг хүртсэн. Газрын тос дараагийн боломжийг нээж буй бололтой. Хөрөнгө оруулагчдын ярьснаар Цагаан ордон Ираны эсрэг хоригоо чангатгаж буй нь түүхий нефтийн үнийг дээш түлхэж, хөгжиж байгаа орнуудыг тэтгэж байна. Даваа гарагт Брент маркийн түүхий нефтийн үнэ 3.5 хувь өсөж, улмаар мягмарт 75 ам.долларыг давсан нь 10 сараас хойш анх удаагийн үзэгдэл болов.



Хэдийгээр өндөр үнэ удаан хадгалагдах баталгаагүй ч шинэ тутам зах зээлүүдийн индекс нефтийн үнээс түүхэн дэмжлэг авлаа. MSCI шинэ зах зээлүүдийн валютын индекс энэ зуунд нефтийн өсөлтийг дагаж, гурван удаа хоёр оронтой тоогоор дээшилсэн. Нефтиэс хамааран мөнгөн тэмдэгт нь хамгийн их дээшилсэн буюу унасан зургаан эдийн засгийг дараах графикаас харна уу.

ОХУ-ын рублийн ханш 2016-2018 оны нефтийн өсөлтийн үед 21 хувиар дээшилсэн нь тэргүүлэх үзүүлэлт болно. Дэлхийд байгалийн хийн үйлдвэрлэлээр тэргүүлдэг тус улсын дотоод валютаар тооцсон өрийн бичгийг хөрөнгө оруулагч нар их хэмжээгээр худалдан авсны дээр төв банк нь оны сүүлээр бодлогоо зөөлрүүлэх төлөвтэй байгаа тул ашгийг нэмэгдүүлнэ. Колумбийн песо мөн сонирхол татна. JPMorgan-ы шинжээчид энэ сарын эхээр түүнийг шинэ тутам зах зээлийн хамгийн хямд валютын нэг гэж нэрлэсэн бол хедж сангийн менежер Саид Хайдар огцом дээшилсэн мөнгөн тэмдэгтийн тоонд оруулсан юм.

Бразилын реалын ханш тогтворгүй байгаа нь тэтгэврийн системийг шинэчлэх төлөвлөгөөнөөс үүдэлтэй. Гэвч сүүлийн муу мэдээнээс шалтгаалан реал унасан гэж Morgan Stanley үнэлжээ. Турк улс нефть импортлогч учир уг тавaарын үнэ өсөхөд хөгжиж буй орнууд дотроо сүүл барихад хүрдэг. Үүнээс гадна Ираны түүхий нефтиэс ихээхэн хамааралтай. Энэ байдал Туркийн лирийг сулруулна гэж Aberdeen Standard сангийн стратегич Францис Хадсон дүгнэсэн байна.

Энэтхэгийн рупи сүүлийн таван жилд түүхий нефтийн үнээс хамгийн муу урвуу хамааралтай валют болж байна. Азийн том гүрний импортын үлэмж хэсгийг нефть бүрдүүлэх агаад 2002 оноос хойш худалдааны алдагдалтай байгаа. Гэхдээ дэлхийд нефтийн импортоор гуравт бичигддэг тус улсын ойрын төлөв нь сонгуулиас хамаарах бололтой. Аргентин, Туркээс гадна Филиппиний песо нефтийн сүүлийн өсөлтөөс хамгийн их хохирсон валют болсон. Гэхдээ энэ удаад дотоод дэмжлэгийн бодлогоос шалтгаалан байдал өөр байх болов уу гэж Baillie Gifford сангийн мөнгөний менежер Салли Грег таамаглаж байна.

ДНХ-ийн сорилын бизнес тэлж, Ancestry IPO хийхээ зарлав

Кил Портер

ДНХ-ийн сорилыг хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, хөрөнгө оруулагч нар эрүүл мэндийн технологид мөнгө цутгах сонирхолтой байгаа. Ийм үед Ancestry.com компани анхдагч зах зээлд гарахад бэлтгэж буй учрыг нь мэдэх эх сурвалж ярилаа. Түүнчлэн Ютад төвтэй Lehi компани энэ оны хоёрдугаар хагаст IPO хийж магадгүй байна. Энэ талаар Ancestry-ийн төлөөлөгч тайлбар өгөхөөс татгалзав. Генетикийн сорилын зах зээл хоёр чиглэлд түргэн тэлж байна. Нэгд, хэрэглэгчид өөрийн эрүүл мэнд ба удамшлын талаар илүү мэдэхийг хүсдэг.

Өнгөрсөн 11-р сарын байдлаар Ancestry 14 сая ДНХ-ын сорилын багц худалдсан бол гол өрсөлдөгч 23andMe 10 саяыг борлуулсан байна.

Нөгөө талаар эрүүл мэндийн үйлчилгээний компаниуд сорилоос бүрдэх асар том генетикийн өгөгдлийн санг сонирхож байгаа юм. Хэрэглэгчдэд шууд хүргэдэг ДНХ-ийн сорилын борлуулалт 2010 онлд 10 сая ам.доллар байсан бол 2017 онд 99 сая болж эрс өссөн ба 2022 онд 310 саяд хүрэх төлөвтэй байгааг Kalorama судалгааны төв мэдээлжээ. Ancestry анх удаа хувьцааны зах зээлд гарах гэж байгаа нь энэ биш. Эднийх 2009 онд анх хувьцаа гаргаж, 100 сая ам.доллар босгосон билээ.

Ургийн мод болон түүхэн баримт бичгийн сайт ажиллуулдаг тус компанийн үнэлгээ 2016 онд 2.6 тэрбум ам.доллар байхад Silver Lake Partners ба GIC компаниуд үлэмж хэмжээний багц худалдан авсан байна. Дараа жил нь IPO хийх санаачилга гаргасан боловч хэрэгжүүлээгүйг нь эх сурвалж хэллээ. Компанийн сүүлийн төлөвлөгөөг мэдэх хүмүүсийн ярьснаар Ancestry-ийн удирдлага хувьцааны зах зээлд буцаж ирэх цаг болсон гэж үзсэний дээр өсөлтийг хурдасгаж, 23andMe зэрэг генетикийн сорилын компаниудтай өрсөлдөхөд дэмжлэг болно гэж найдаж байна.

Хамгийн сүүлд буюу 2017 онд олон нийтэд танилцуулсан тайлангаас үзэхэд эднийх борлуулалтаасаа нэг тэрбум ам.доллар олжээ. Өнгөрсөн онд Ancestry Марго Жеоржидисыг ерөнхий захирлаараа томилсон. Өнгөрсөн 11 дүгээр сарын байдлаар Ancestry 14 сая ДНХ-ын сорилын багц худалдсан бол гол өрсөлдөгч 23andMe компани 10 саяыг борлуулсан байна.

23andMe саяхан GSK эм үйлдвэрлэгчтэй 300 саяын гэрээ байгуулж, эрүүл мэндийн сорилын салбар руу орлоо. Тэгвэл Ancestry ч мөн энэ замаар явах төлөвтэй байгаа. Генетикийн сорилын зах зээлд Helix, Color Genomics зэрэг шинэ тоглогчид орж ирснээр өрсөлдөөн улам хурцдаж байна.

Эдийн засаг

О.Амартүвшин: Төр дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх хэрэггүй

Төр, хувийн хэвшлийн хүрч чадахгүй орон зайг мэргэжлийн холбоодоор нөхөх боломжтой

Э.Батцэцэг
ЗГМ

МХАҮТ-ын байр суурь бизнес эрхлэгчдийг бүхэлд нь төлөөлдөг утгаараа үргэлж үнэ цэнэтэй байдаг. Дэлхийн улсууд тэгш байдлаар тогтвортой хөгжих арга замаа хэлэлцэн баталж, нэгэн зүгт харж буй энэ үед Монгол Улсын хөгжлийн бодлогыг зангидах чухал хүчин болох хувийн хэвшлийн оролцооны талаар танхимын ерөнхийлөгч О.Амартүвшинтэй ярилцлаа. Тэрбээр байнга яригддаг сэдэв болох бизнесийн эрүүл орчныг бүрдүүлэхэд бодит ямар ажил хийж байгаа талаараа хуваалцлаа.

Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

Гэтэл төр шийд, хувийн хэвшил хий гэж олон жил ойлголцохгүй дундаа хаясаар асуудал гамшгийн хэмжээнд хүрч ужгирч байна. Иймэрхүү нийгмийн томоохон төслүүдийг төр яаж бодлогоор дэмжих вэ, хувийн хэвшил хэрхэн хийх вэ гэдгийг л тодорхой болгож хуульчлах юм.

-Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо гэж байдаг. Энд бизнес эрхлэгчдийн саналыг тусгасан олон асуудал хэлэлцдэг байх?

-Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо нь бизнесийн эрх зүйтэй холбоотой тулгарч буй асуудлыг төртэй хамтран хэлэлцэж, санаа оноогоо тусгадаг бүтэц юм. Хувийн хэвшил эхэлж санаачилгаа гаргаж, асуудлаа дэвшүүлээд, төрд хүргэдэг механизмаар ажиллаж байна. Ийм хэлбэрээр хэд хэдэн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Үүний нэг нь Зөвшөөрлийн тухай хуулийн хэлэлцүүлэг юм. Бизнес эрхлэгчдийнхээ төлөөллийг хамруулаад тодорхойгүй олон зүйлд саналаа оруулсан. Хоёр дахь том ажил нь удахгүй болох гэж байгаа форум юм.

Төр хувийн хэвшлийн хамгийн оновчтой хамтын ажиллааны үндсэн дээр л улс орон хөгжин цэцэглэж, иргэдийн сайн сайхан амьдрал дээшилнэ гэж олон улсын байгууллагууд зөвлөдөг. Төр нь илүү эрхтэй, эсвэл хувийн хэвшил нь давуу байх ёстой гэхгүйгээр балансыг зөв барих нь чухал.

-Мэргэжлийн холбоодын эрх зүйн байдлыг сайжруулах талаар хэлэлцэнэ гэсэн. Энэ талаар ямар зохицуулалт оруулах вэ?

-Төрийн бус байгууллагуудын эрх зүйн байдлыг нарийвлан зохицуулах зайлшгүй шаардлага байна. Өнөөдөр 17-18 мянган ТББ бий. Эдгээрийн ихэнх нь зөвхөн цаасан дээр л байгууллага хэлбэртэй, тамга тэмдгээ цүнхлээд, хэсэг хүний эрх ашгийн төлөө ажилладаг нь нууц биш. Ямар сайндаа л "тэдний зорилго нь бүхнийг эсэргүүцнэ" гэж шоглодог байх вэ дээ. Иргэний нийгмийн бусад байгууллагадаа ч, төрийн үйл ажиллагаанд, бизнесийнхэнд ч төвөг болдог "шантаажчид"-ыг цэгцлэх цаг нь болсон. ТББ-ын тухай хуульд дүрмийн бус үйл ажиллагаа явуулсан, хууль зөрчсөн үйлдэл гаргасан бол татан буулгана гэж заасан байдаг ч хэрэгждэггүй.

Танхимын зүгээс Баялаг бүтээгчдийг дэмжих багц хууль боловсруулаад энэ форумаар хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Үүнд мэргэжлийн холбоодыг чадавхжуулах асуудал яригдана. Жишээлбэл, барилгын салбарт 40-өөд ТББ бий. Дөчин янзын юм яриад байхаар энэ салбарын хууль тогтоомжийг сайжруулахад хүндрэлтэй. Ийм нэгдмэл бус байдал нь төрд асуудлаа танилцуулж, шийдвэрлүүлэх боломжгүй болгож байна. Тиймээс олон ТББ, мэргэжлийн холбоодыг цэгцэлж, нэгтгэсний эцэст салбарын гажуудлыг засаж сайжруулах боломж гарах юм.

-Нийгмийн хариуцлагыг хуульчлахаар ярилцаж байгаа юм билээ. Сургуульд компьютер бэлэглэж, сумын наадмыг ивээн тэтгэдэг бол нийгмийн хариуцлагатай сайн компани гэж үздэг л дээ?

-Тийм ээ, Монголд таны хэлсэнчлэн хандив, эсвэл төрийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих хүрээнд нийгмийн хариуцлагыг авч үзээд байна л даа. Гэтэл суурь утга нь орчныг сайжруулах, тохиолдож болзошгүй эрсдлээс зайлсхийх, хамгаалах гэх мэт маш өргөн ойлголттой. Гадны орнуудад компанийн нийгмийн хариуцлагыг олон нийтийн байгууллагын оролцоонд уялдуулж шийддэг. Хувийн хэвшлийнхэн өөрсдийн философиор асуудалд хандаж, аливаа нэг үйл ажиллагааг дэмждэг ч, энэ нь түр зуурын аргацаасан байдлаар өнгөрдөг. Тогтвортой, урт хугацааны, асуудлыг шийдэж чаддаггүй нь нууц биш. Харин олон улсад татварын тодорхой хувийг тухайлсан олон нийтийн байгууллагад өгч, тэр хэмжээгээр нь татвараас чөлөөлөх тогтолцоо хуульчлагдсан байдаг. Ийм тогтвортой санхүүжилттэй, нээлттэй засаглалтай ТББ-ууд салбарынхаа бодлогын хэмжээнд хөрөнгө зарцуулан ажиллах нь илүү үр дүнтэй. Засаглалыг эрүүлжүүлж, санхүүжилтийг нь ил тод болгоод, үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлж өгвөл "шантаажны" гэгдэх байгууллагууд нь аяндаа шахагдан, цэвэршинэ. Төр, хувийн хэвшлийн хүрч чадахгүй байгаа орон зайг ийм мэргэжлийн холбоодоор бүрэн дүүрэн нөхөх боломжтой.

-Тогтвортой хөгжлийн зорилт дахь "Хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчим иргэний нийгмийн байгууллагуудаар дамжин хэрэгжих боломжтой болох нь ээ?

-Хувийн хэвшлийн хамгийн том оролцоо бол ажлын байрыг ихээр нэмэгдүүлэх асуудал. Нэмэгдсэн ажлын байрыг дагаад бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэл өснө, төрд төвлөрөх татвараар төсөв нэмэгдэнэ. Төсвөөс иргэдийн эрүүл, боловсролтой, аюулгүй очинд амьдруулах нөхцөлийг хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. Үүнд олон нийтийн байгууллагын оролцоо яригдана. Энэ гурав тулгын чулуу шиг тэгш байсан цагт эрүүл нийгмийг байгуулах тухай ярьж болно. Аль нэг нь томорчихвол тулга тогтохгүй шүү дээ. Зөв балансаа л барих хэрэгтэй.

-Төрийн оролцооны талаарх хуулийн төсөлд Концессийн хуулийн малгай болохуйц бодлогын асуудлыг тусгана гэсэн. Хувийн хэвшилд илүү боломж олгох уу?

-Концесс бол төр, хувийн хэвшлийн түншлэлийн чухал илрэл. Хэдэн жилийн өмнө Улаанбаатар хотын удирдлагууд Улаанбаатарын танхимтай хамтарч төр хувийн хэвшлийн түншлэлийг яаж зөв явуулах асуудлыг гаргаж ирсэн. Төр нь баталгаа гаргаж, хувийн хэвшил гаднаас хөрөнгө оруулалт татах зэргээр хамтраад бүтээн байгуулалт хийх арга замыг дэвшүүлж байсан.

Хуулийн орчин эрүүл бус бол тогтвортой хөгжил гэж яриад хэрэггүй

Магадгүй, төрд гэр хорооллын асуудлыг шийдэхэд зориулсан 100 тэрбум төгрөг байхад, хувийн хэвшил хамтарч, Засгийн газар баталгаа гаргаснаар түүнээс илүү мөнгө босгоод урт хугацаандаа агаар, орчны бохирдлыг шийдэх боломж гаргаж ирж болох юм. Гэтэл төр шийд, хувийн хэвшил хий гэж олон жил ойлголцохгүй дундаа хаясаар асуудал гамшгийн хэмжээнд хүрч ужгирч байна. Иймэрхүү нийгмийн томоохон төслүүдийг төр яаж бодлогоор дэмжих вэ, хувийн хэвшил хэрхэн хийх вэ гэдгийг л тодорхой болгож хуульчлах юм. Гэхдээ одоогоор хуулийн төслийн анхан шатны танилцуулга л яригдаж байгаа шүү дээ.

-Баялаг бүтээгчдийг дэмжих багц хууль хүлээж буй үр дүнгээр батлагдвал бизнесмэнүүд улс төрд орох үзэгдэл буурах уу?

-Манайд сайн, чанартай хуулиуд бий. Харин хэрэгжилт нь хууль шигээ сайн байж чаддаггүй. Бизнесийн орчныг сайжруулахуйц сайн хуулиуд батлаж байна. Гэхдээ төрийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн, бизнесийг хааж боосон чанартай зарим зохицуулалт хуульд шингээд ирэхээр ойлгомжгүй байдал, хүндрэлүүд үүсдэг. Энэ хүндрэлийг гаргахгүйн тулд, гарсныг нь залруулахын төлөө бизнесмэнүүд улс төрд орж байна. Тэгэхээр бизнесийн эрүүл орчныг бүрдүүлчихвэл улс төрөөс аяндаа гарна.

-Хувийн хэвшлийнхэн дотроо асуудлуудаа ярилцах үед ямар бэрхшээл байдаг вэ?

-Өмнө гарч байсан хуулийн төслүүдийг харахад дор бүрнээ л салбарынхан саналаа тусгахыг эрмэлзэж байсан юм билээ. Ингэж олон төрлийн үзэл бодол ороод ирэхээр хуульд нэгдсэн байдлаар санаагаа тусгаж чаддаггүй. Одоо бол дотооддоо ярилцаад, олон асуудлаа ач холбогдлоор нь эрэмбэлж, нэгтгэж оруулдаг. Зайлшгүй байх ёстой зүйлээ ажлын хэсэгт зөв ойлгуулж чаддаг болсон. Энэ жишгээр Хөдөлмөрийн багц хуульд бүрэн дүүрэн саналаа тусгаж чадлаа, Татварын багц хуульд хүссэн хэмжээндээ биш ч, тодорхой хэмжээнд орууллаа. Одоо Зөвшөөрлийн тухай хуульд сайн ажиллаж байна. Энэ мэтчилэн Мэргэжлийн холбоодын тухай хууль, Компанийн засаглалын тухай, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тухай, Өрсөлдөөний тухай гээд олон хуулийн өөрчлөлтөд танхим дээрээ нэгдээд, мэргэжлийн хуульчдаа оролцуулж, олон дахин хэлэлцэх хэрэгтэй байна. Монголын бүх бизнес эрхлэгчид нэгдэж саналыг дэвшүүлбэл тодорхой болоод ирнэ шүү дээ.

-Олон улсын туршлагаас санаа авсан байх?

-Ардчилсан чөлөөт эдийн засгийн нийгмийг сонгон хөгжиж байгаа ихэнх улсад ийм эрүүл тогтолцоо аль хэдийн тогтсон. Бизнесийн орчинтой холбоотой аливаа хууль, журамд өөрчлөлт оруулах гэж байгаа бол төв байгууллагын саналыг заавал тусгаж, дэмжлэгийг нь авч байж цаашаа явдаг. Танхимаас дэмжлэг авч чадаагүй хууль батлагддаггүй. Баялаг бүтээж буй компаниудын татвараас улсын төсөв бүрддэг учраас тэдний санал чухал байдаг.

-Тогтвортой хөгжлийг хангах санхүүжилтийн 70-80%-ийг хувийн хэвшлээс гаргана гэж дэлхий нийтээр тогтсон. Гэтэл Монголд ийм хэмжээний санхүүжилт гаргаад өгөх том компани цөөхөн шүү дээ?

-Бизнесийн хэлээр энэ бол "төчнөөн тэрбумыг шууд өг" гэсэн үг биш л дээ. Төрийн зүгээс зөв бодлогоор зохицуулж, дээр хэлсэн татвараар нийгмийн хариуцлагыг дэмжих, урт хугацааны зээл авах, хөрөнгө оруулалтын орчныг нь хамгаалах зэргээр шаардлагатай гаргалгааг нь хийж өгвөл 80 байтугай хувийн санхүүжилтийг хувийн хэвшлээс босгож чадна. Харин хуулийн орчныг эрүүл бус, хавчиж дарамталсан байдалтай тогтоож, өргөжин тэлэх боломжийг нь хаачихаад, "та нар ажилла" гэвэл тогтвортой хөгжил гэж яриад хэрэггүй.

Бизнес эрхлэгчдийн төлсөн татварын мөнгөөр нийгмийн олон асуудлыг шийдэхэд төр өөрөө бүх эрхийг хэрэгжүүлж байна. Утааг бууруулах, хүүхэд эмэгтэйчүүдийн асуудал, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих гэх мэтээр маш их мөнгийг зарж байна. Харамсалтай нь авлига, хүнд суртлаас болж ямар ч үр дүнгүй, салхинд хийсгэсээр байгааг залруулахгүй удлаа. Гэтэл яг тэр чиглэлд ил тод үйл ажиллагаа явуулдаг, сайн засаглалтай олон нийтийн байгууллагад санхүүжилтийг шууд өгвөл үр дүн нь дороо л мэдрэгдээд ирнэ. Төр дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх хэрэггүй. Мөн тухайн асуудлыг шийдвэрлүүлэхээр олон нийтийн байгууллагад мөнгөө өгсөн компани хяналтаа шууд тавьж болно. Төр лүү орчихоор бид хянаж чадахгүй болчихоод байна.

-Тодорхой жишээ хэлж өгөөч?

-Нэг жишээ хэлье л дээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих хуульд 25 ажилтан тутамд нэг хөгжлийн бэрхшээлтэй хүн байна, ажиллуулаагүй тохиолдолд тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн санд мөнгө төлнө гэсэн зохицуулалттай. Энэ хууль хэрэгжсэнээр тухайн санд маш их хэмжээний мөнгө цуглаж эхэлнэ. Гэтэл энэ сангийн чиг үүргийг төр хэрэгжүүлээд, өөрөө өөртөө хяналтаа тавиад явах юм гэнэ. Зүй нь бол бизнес эрхлэгчид энэ санд төвлөрөх их хэмжээний мөнгөө өөрсдийн сонгосон удирдах зөвлөл дор, ТББ, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр нь менежмент хийлгээд зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг явуулбал маш үр дүнтэй ажил болох байлаа. Хувийн хэвшлийнхэн нэг л зүйлийг хэлж байна. "Мөнгийг нь төлж болно. Харин хэн энэ санг удирдаж, хөрөнгө зарцуулах вэ. ЖДҮ шиг юм болгож орхивол зорилго нь биелэхгүй" гэдэг. Засаглалыг нь сайжруулаад, холбогдох байгууллагаар зөв менежмент хийлгэж ажиллуулах нөхцөлийг төр бүрдүүлж өгвөл үүргээ хангалттай биелүүлж байгаа нь тэр шүү дээ. [ЗГМ]

УУЛ УУРХАЙ

Хятадын коксжих нүүрсний импорт 53 хувиар өсөв

БНХАУ-ын коксжих нүүрсний импорт гуравдугаар сард өмнөх оны мөн үеэс 53 хувиар өсөж, 6.1 сая тоннд хүрлээ. Өсөлтийн хувь нь 2017 оны дөрөвдүгээр сараас хойших хамгийн өндөр дүнд тооцогдож байна. Коксжих нүүрсний импортыг оны эхний гурван сарын байдлаар авч үзвэл 35 хувиар өсөж, 16.4 сая тонн хүрсэн байна. Харин эрчим хүчний нүүрсийг нэгтгэсэн нийт дүн гуравдугаар сард 12 хувиар буурчээ. Коксжих нүүрсний импорт өнгөрсөн сард ийн өндөр дүнгээр өссөн нь хоёрдугаар сард уламжлалт сар шинийн баяр тохиож арилжаа хумигдаж, улмаар гуравдугаар сард эргээд сэргэсэнтэй холбоотой гэж шинжээчид тайлбарлаж байна. Мөн дөрөвдүгээр сард коксжих нүүрсний импортын дүн буурч магадгүй гэж шинжээчид үзэж байна.

БНХАУ-ын эрх баригчид импортын нүүрсний чанарын шаардлагаа өндөрсгөж байгаа. Ялангуяа радио идэвхт агууламжийг нягтлан шалгах болжээ. Мөн Австралиас орж ирж буй нүүрсний гаалийн бүрдүүлэлт хийх явцыг удаашруулж байгаа юм.

ЗГМ ТОВЧХОН

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

52.5

Сая төгрөг. Монголын хөрөнгийн биржийн лхагва гарагийн арилжаагаар 31 хувьцаат компанийн 52.2 сая төгрөгийн 335 мянган ширхэг хувьцааг арилжжээ. Үүнээс есөн компанийн хувьцааны ханш өслөө.

» ХУВЬЦАА

15

Хувь. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Хөх ган" компанийн хувьцааны ханш 15 хувиар чангарч, ханшийн өсөлтөөрөө хөрөнгийн биржийн арилжааг тэргүүллээ. Мөн "Монгол шуудан" компанийн үнэт цаасны ханш 10 орчим хувиар чангарч, өсөлтийг удаалсан байна. Харин "Өндөрхаан" компанийн хувьцааны ханш 14.8 хувиар уруудсан нь огцом уналтад тооцогдож байна.

» ТҮҮХИЙ ЭД

0.4

Хувь. Олон улсын зах зээлд Brent төрлийн газрын тосны ханш 0.4 хувиар өсөж, 74.2 ам.доллартай тэнцэв.

» ЗАХ ЗЭЭЛ

0.4

Хувь. Ази номхон далайн бүсийн хөрөнгийн зах зээлийн жишиг индекс болох MSCI Asia Pacific лхагва гарагт 0.4 хувиар буурч, сүүлийн тав хоногийн доод цэгт хүрлээ.

» САНХҮҮ

0.1

Хувь. Ам.доллартай харьцах иенийн ханш 0.05 хувиар өсөж, 111.81 нэгжид хүрлээ. Харин фунттай харьцах ам.долларын ханш 0.1 хувиар суларч, 1.2925 нэгжтэй тэнцэв.

ИНДЕКС

0.2

Хувь. Bloomberg-ээс тооцдог ам.долларын спот индекс 0.2 хувиар өслөө. Ингэснээр тус индекс сар гаруйн дээд цэгт хүрсэн байна.

» БОНД

3

Нэгж. АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж гурван суурь нэгжээр буурч, сүүлийн арав хоногийн доод цэгт дөхлөө.

» НОГДОЛ АШИГ

10

Тэрбум төгрөг. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд ногдол ашиг болон компаниудын ногдол хувийн төлбөрийн 10 гаруй тэрбум төгрөг эзэндээ очилгүй хадгалагдаж байгааг санхүүгийн тайландаа тусгажээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,637.96
Евро	2,955.70
Японы иен	23.60
ОХУ-ын рубль	41.18
БНХАУ-ын юань	392.55
БНСУ-ын вон	2.29

Эдийн засаг

ДЭД БҮТЭЦ

Тээвэрлэх шугам хоолойгүй бол сая саяар нь нефть нэрээд нэмэргүй

Нефтийн үйлдвэрийн ирээдүйг дэд бүтэц шийднэ

651км
Дорноговь хүртэлх шугам хоолойн урт

$300сая
Шугам хоолойн нийт өртөг

Монгол Улсын нийт импортын бүтэц

» **30%** Газрын тос

» **70%** Бусад бүх бараа бүтээгдэхүүн

- **2017.06** Төслийн нарийвчлсан ТЭЗҮ боловсруулах гэрээ
- **2017.11** Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулж дуусах
- **2018.02** Ерөнхий зураг төслийн ажил
- **2018.10** Нарийвчилсан зураг төсөл, инженерчлэлийн ажил
- **2019.01** Технологийн иж бүрдлийн захиалга, хангамж ба барилгын ажил эхлэх
- **2020.01** Төслийн барилга угсралтын ажлын дунд шат
- **2021.05** Үйлдвэр болон түүхий тос тээвэрлэх дэд бүтцийг улсын комисс хүлээн авах
- **2021.07** Боловсруулах үйлдвэрийн туршилтын үе шат
- **2021.10** Боловсруулах үйлдвэр бүрэн ашиглалтад орох

Г.Байгал
@baigalZGM

Монголчууд хэтэвчин дэх таван төгрөг тутмынхаа нэгийг шатахуунд зарцуулдаг. Мөн дөрвөн ам.доллар тутмынхаа нэгийг нефтийн бүтээгдэхүүн худалдан авахаар хилийн чанад руу урсгадаг байна. Өрхийн хэтэвчээс эхлээд улсын сан хөмрөгийг хүртэл хөндддөг шатахуун дагасан валютын урсгалыг дотоодод нь үлдээж, иргэдээ үнийн дарамтаас хамгаалахын тулд Монгол Улсын Засгийн газар нефть нэрэх үйлдвэрийн төслийг урагшлуулаад удаагүй байна.

Монгол хүн бүр чих тавин хүлээж буй энэ үйлдвэр тойрсон шинэ мэдээллүүдийн зах зухаас нь уншигч та сонссон байх. Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр босох уг үйлдвэрийн менежментийн зөвлөхөөр тус улсын Engineers India Limited компани шалгарсан. Тус компанийн Ажлын хэсэг энэ сард багтаан манай улсад ажиллах аж.

Монголчууд олон жил хүсэн хүлээсэн уг үйлдвэрийг эрчим хүчээр тэжээх цахилгааны шугам болон төмөр замын ажил дуусаад байна. Ирэх есдүгээр сард авто замын ажлыг бэлэн болгоно хэмээн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам мэдээлэв. Төслийн төлөвлөгөөгөөр ирэх оны эхний улирал гэхэд үйлдвэрийн барилга угсралт дунд шатандаа орох учиртай.

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд цаасан дээр бараг 4-5 удаа нүүлгэсэн нефтийн үйлдвэрийг өнгөрсөн онд эх орны зүүн өмнөд хэсэг болох Дорноговь аймгийн Алтанширээ суманд барихаар болсон. Харин жилд 1.5 сая тонн газрын тос хэрэглэх энэ аварга үйлдвэрийг түүхий эдээр хангах бэлэн орд энэ бүс нутагт одоогоор байхгүй. Тиймээс Монгол орны зүүн хязгаарт орших Дорнод аймгийн XIX, XXI дүгээр талбайгаас түүхий эд татаж, боловсруулах үйлдвэрт нийлүүлэхээр болсон юм. Хэрэв түүхий эд зөөж, түлш түгээх шугам хоолой үгүй бол хэчнээн өндөр хүчин чадалтай үйлдвэр барьж, сая саяар нь нефть нэрээд ямар ч нэмэргүй нь ойлгомжтой. Тиймээс зүүн хязгаарт буй түүхий эдийг өмнө зүг рүү зөөх шаардлага үүсээд байна.

Дэлхий дахинд газрын тосыг далай, шугам хоолой, авто болон төмөр замаар тээдэг. Эдгээрээс хамгийн хямд нь усан тээвэр боловч эх газраар хүрээлүүлсэн Монгол Улсад далайн зам тавих боломжгүй. Тиймээс дараагийн өртөг багатай зам болох шугам хоолойн тээврээр тос тээхээр салбарын бодлого тодорхойлогчид шийдээд байгаа юм. Хоолойн тээвэр нь өртөг багатайгаас гадна байгальд ээлтэй. Улс орнууд ил болон газрын гүнд хоолой байгуулж, түүхий эд, бүтээгдэхүүнээ зөөдөг. Манай хойд хөршийн нефтийн дийлэнх үйлдвэр газар доогуурх хоолойгоор тээвэрлэлтээ шийддэг аж.

Ирэх есдүгээр сард авто замын ажлыг дуусгана гэж салбарын яам мэдээлэв

Монгол Улс газрын тосны хоолойг аль чиглэлээр, хэрхэн тавих зэргийг судалж байгаа. Дорнодын газрын тосны талбайгаас Алтанширээ сум хүртэл 651 километр шугам хоолой татах шаардлагатай гэсэн тооцоо гарчээ. Тэгвэл хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг дайрах энэ хоолой нь шатахуун түлшний хараат байдлаас ангижрахад Монголын талын гүйцэтгэх ёстой гол ажил юм.

Хоёр улсын хамтын ажиллагаагаар нефть нэрэх үйлдвэрийг Энэтхэг улс бүрэн хариуцна. Харин үйлдвэрээс бусад нь буюу газрын тос дамжуулах хоолой, цахилгаан станц, дэд бүтцийн барилга байгууламжийн ажил нь монголчуудын толгой дээр бууж байгаа юм. Эх орондоо төдийгүй тив дэлхийд газрын тосны олон арван төслийг амжилттай хэрэгжүүлсэн Энэтхэг улс 1.5 сая тонны боловсруулах үйлдвэрийг бидэнтэй, бидэнгүй барьж байгуулчихна. Харин бид хүлээсэн үүргээ хариуцлагатай, ажил хэрэгчээр гүйцэтгэх болов уу.

Дэд бүтэцгүй л бол энэ өндөр үнэтэй үйлдвэр амьгүй аварга байгууламж, нүсэр тоног төхөөрөмж л болж хувирна. Тиймээс монголчуудын хичээл зүтгэл, ажил хэрэгч, хариуцлагатай байдал нефтийн үйлдвэрийн хувь заяаг шийдэх нь. Дэд бүтцийн бүтээн байгуулалтад Хөгжлийн банкнаас 250 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор болсныг Ашигт малтмал, газрын тосны газраас мэдээлж байна. Энэ мөнгөөр дэд бүтцийн бүх ажлыг хийхээр төлөвлөжээ. Харин шугам хоолойн өртөг урьдчилсан тооцоогоор 300 гаруй сая ам.доллар буюу 700 гаруй тэрбум төгрөг болох ч хөрөнгийг эх үүсвэрээ хэрхэн шийдэхийг дарга нар хэлсэнгүй.

Дээрээс нь газрын тосны шугам хоолой нь тоглоом биш. Эн тэргүүнд шугам хоолой дайрах газар нутгуудыг судалж, замд нь таарах нуур, цөөрөм, уул давааг тооцох нь чухал. Мөн хасах, нэмэх 40 хэмд хэлбэлздэг Монгол Улс анх удаагаа хоолойгоор газрын тосоо тээх гэж байна. Цаг уурын эрс тэс энэ нөхцөлд газрын тос царцах эрсдэл тулгардаг бөгөөд ийм тохиолдолд дахин шингэрүүлэх үйлдвэр барих шаардлага тулгардаг аж. Цаашлаад хээр зэлүүд газар хоолой бариад орчихож болохгүй. Далайд тээврийн хоолой задарч газрын тос асгарчээ, нефтийн түүхий эдийн дамжуулах хоолой дэлбэрчээ... гэсэн мэдээтэй уншигч та таарсан байж магадгүй. Өөрөөр хэлбэл, шугам хоолой нь байнгын хараа хамгаалалт, засвар үйлчилгээ нэхдэг. Ингээд тооцохоор шугам хоолой нь үйлдвэрээс дутахгүй тооцоо судалгаа, санхүүжилт нэхэхээр байна.

Тэртээ 1996 онд Тамсагийн ордоос газрын тос оргилж, тухайн үеийн удирдлага дээлийнхээ энгэрт мялааж байсан цагаас хойш газрын тосоо түүхийгээр хил давуулснаас өөр энэ салбарт амжилт олоогүй монголчуудад нефть нэрэх үйлдвэр нь нэвтэрхий мэддэг хуучин танил бус цоо шинэ талбар байх нь ойлгомжтой.

- **Газрын тос боловсруулах үйлдвэрийг эрчим хүчээр хангах цахилгааны шугам болон төмөр замын ажил дуусаад байна.**
- **Төслийн төлөвлөөгөөгөөр ирэх оны эхний улирал гэхэд үйлдвэрийн барилга угсралт дунд шатандаа орох учиртай.**
- **Энэтхэг улс 1.5 сая тонны боловсруулах үйлдвэрийг бидэнтэй, бидэнгүй барьж байгуулчихна. Харин бид хүлээсэн үүргээ хариуцлагатай, ажил хэрэгчээр гүйцэтгэх болов уу.**

Бид өнгөрсөн 30 орчим жил энэ талаар үлгэр домог болтол нь ярихдаа ганц үйлдвэр байгуулчихвал л монголчуудыг шатахууны гачлангаас гаргаж, хил даван урсдаг валютын урсгалаа тогтоочих юм шиг төсөөлж ирсэн нь үнэн. Гэтэл улс орны хөгжлийг нэг шат ахиулдаг энэ хүнд үйлдвэр нь зөвхөн тоног төхөөрөмж, түүнийг агуулах барилга байгууламжаас гадна зам, дэд бүтцийн аварга бүтээн байгуулалт, ажил хэрэгч, нарийн тооцоо судалгаа, төлөвлөлт шаардаж байна.

Энэтхэг улс үйлдвэр байгууллаа гэхэд уг бүтээн байгуулалтын ирээдүй нь монголчуудаас хамаарах аж. Тодруулбал, Дорнодоос хямд үнээр түүхий тосоо авч, түүнийгээ өртөг багатайгаар эцсийн хэрэглэгчдэд хүргэж байж тус төсөл үр ашгаа өгнө. Ингэснээр үйлдвэр байгуулсны үр шимийг олон жилийн турш түлш шатахуун, өргөн хэрэглээний барааны үнийн дарамтад нухлуулж буй Монголын ард түмэн хүртэж, магнай нь тэнийнэ. Цаашлаад бид үйлдвэр байгуулахаар Энэтхэгээс зээлсэн өндөр үнийн дүн бүхий зээл төлнө. Ингээд бодохоор нефтийн үйлдвэр тогтвортой, ашигтай ажиллах эсэхийг шугам хоолой, дэд бүтцийн хөгжил л шийднэ. Эс бөгөөс энэ төрлийн үйлдвэр татвар төлөгчдийн татаасаар амиа зогоодог, төсвийн дарамт болдог түүх бий. [ЗГМ]

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

АПУ ХК



Өдөр ↓0.17% Сар ↑ Жил ↑

МОНГОЛ ШУУДАН ХК



Өдөр ↓ 10.08% Сар ↓ Жил ↑

ГОВЬ ХК



Өдөр ↓ 1.01% Сар ↑ Жил ↑

СҮҮ ХК



Өдөр ↑3.03% Сар ↑ Жил ↑

Turquoise Hill Resources Ltd Торонто



Өдөр ↓ 0.91% Сар ↓ Жил ↓

Erdene Resource Development Торонто



Өдөр ↑ 2.38% Сар ↑ Жил ↓

Aspire Mining Австрали



Өдөр ↓ 11.11% Сар ↓ Жил ↓

Rio Tinto Австрали



Өдөр ↓ 1.11% Сар ↑ Жил ↓

DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
0.55%	0.88%	0.35%	0.27%	0.09%	0.09%	0.54%	0.02%